

**ТАВАНТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО
БА ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ОЛОН НИЙТИЙН САНАЛ ШҮҮМЖ**
(Лавлагаа мэдээлэл)

*Д. Мягмарцэрэн, Ч. Базар (Ph.D), Ц. Батдорж, С. Дорждагва, Б. Дуламсүрэн,
Б. Мөнхцэцэг, Ч. Онончимэг, Н. Түвшинтөгс, Ц. Элбэгзаяа*

ОРШИЛ

Судалгааны энэхүү хэсэгт “Тавантолгойн ордыг ашиглах талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, олон нийтээс гарч буй санал шүүмжид хийсэн контент анализ ” сэдвийн хүрээнд УИХ-ын 39 дүгээр тогтоолын хэрэгжилтийн үр дүн болон орд ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар олон нийтээс санал болгож буй хувилбар зэргийг нэгтгэн лавлагаа мэдээллийн хэлбэрээр бэлтгэв. Судалгааны үр дүнд Тавантолгойн нүүрсний орд ашиглалтын талаар төрөөс баримталж буй өнөөгийн бодлогын хүрээнд уг ордыг Монгол улсад үр өгөөжтэйгээр ашиглаж чадах эсэх, энэ талаар олон нийт ямар саналтай байгаа зэргийг тодруулахыг зорьсон болно.

Судалгааны бүтэц:

- Тавантолгойн ордыг ашиглах талаар төрөөс баримталж буй бодлого, холбогдох шийдвэрүүд
- УИХ болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудаас авсан арга хэмжээ, хийгдсэн ажлууд
- Таван толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний зарчим, хэрэгжилт
- Тендерт оролцогч, шалгарах магадлал бүхий гадаадын хөрөнгө оруулагч компаниуд
- Ордын ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар төрийн болон олон нийтийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдын санал болгож буй хувилбарууд гэсэн үндсэн хэсгүүдтэй.

Судалгааны үр дүн:

Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар өнөөг хүртэл хийгдсэн ажлуудын үр дүнг нэгтгэн харахад одоогоор Монгол улс уг ордоос хэдий хэмжээний ашиг хүртэх эсэхийг шууд дүгнэхэд хэцүү байна. Хэдий хэмжээний ашиг хүртэхийг тооцохын тулд эхний ээлжинд дор хаяж Тавантолгойн ордын ТЭЗҮ, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн зах зээлийн үнэлгээ шаардлагатай. Гэтэл судалгааны явцад цуглуулсан мэдээллүүдээс харахад одоо болтол ТЭЗҮ, үнэлгээний талаар тодорхой тоо баримт байхгүй байна.

Тавантолгойг ашиглаад эхлэхээр Монгол улс ашиг олно гэсэн тойм багцаа л байгаа болохоос уг орд чухам ямар үнэ цэнэтэй, эдийн засгийн хэр өгөөжтэй, хэчнээн хэмжээний хөрөнгөөр ямар бүтээн байгуулалт хийгдэх нь тодорхойгүй байна. Гэтэл ийнхүү урьдчилсан тооцоо байхгүйгээр Ажил гүйцэтгэх, Хөрөнгө оруулах талаар эхний хэлэлцээрүүд хийж оролцогчдыг тодруулж байгаа нь ордоос олох ашгийн хэмжээг бууруулсан байдлаар тохиролцох, магадгүй зарим тохиолдолд Монгол улсад ашиггүй гэрээ хэлэлцээрүүд байгуулагдаж болох талтай.

Иймээс ордын ТЭЗҮ-г хийж, нөөцийг нь олон улсын стандартын дагуу тогтоож, удирдлагын багаа бүрдүүлсний дараа олон улсад нэр хүнд бүхий компаниар үнэлгээ

хийлгэх шаардлагатай. Ингэснийхээ дараа сонгосон биржтэйгээ харилцаж, биржээс томилогдсон зөвлөхүүдтэй хамтран ажилласнаар олон улсын бирж дээр IPO хийх эрхтэй болно. Хамгийн гол зүйл нь “ЭрдэнэсТавантолгой” ХК-ийн 30 хувийн хувьцаа ямар үнэд хүрэх вэ гэдэг тодорхойгүй байна. Тавантолгой ордын баялагт бодитой үнэлгээ хийгдээгүй болохоор одоо хаа хаанаа зөвхөн бүдүүн бараг тооцоогоор л ярьцгааж байна. Энэ нь олон нийтэд Тавантолгой орд ашиглалтын гэрээг Засгийн газар хийж чадахгүй гэсэн урьдчилсан болгоомжлол үүсгэсэн байна.

Гэхдээ одоогоор эдгээрийг буруутгах аргагүй бөгөөд ТЭЗҮ боловсруулах явц болон бусад холбогдох гэрээ хэлэлцээрийн явц эхлэлийн шатандаа байгаа тул цаашид сайжрах болно гэж найдаж болох юм. Судалгааны зорилго ч орд ашиглалтын талаар одоо хийгдэж байгаа ажлуудыг үнэлж дүгнэхэд чиглээгүй бөгөөд болж буй үйл явцыг л нэгтгэн харуулахыг зорьж лавлагаа мэдээлэл бэлтгэсэн. Цаашид холбогдох тоо баримтууд тодорхой болохын хэрээр дүн шинжилгээнд чиглэсэн судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийх болно.

1. ТАВАНТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ХОЛБОГДОХ ШИЙДВЭРҮҮД

УИХ-ын 39 дүгээр тогтоолын хэрэгжилт

Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 272 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийг “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулж, Төрийн өмчийн хорооны 2010 оны 425 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн дүрмийг баталж, орд ашиглалтын ажил толгой компаниас охин компанид шилжих үйл явц хэрэгжиж байна. Энэ оны эхний улиралд багтаж ордын ашиглалтын тусгай зөвшөөрлүүд Эрдэнэс Таван толгой охин компанид шилжих болно.

Засгийн газар 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжүүдэд худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг баталсан. “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн нийт хувьцааны 10 хувийг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх, 10 хувийг аж ахуйн нэгжид нэрлэсэн үнээр худалдах ажлын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж байна.

Монгол Улсын нийт иргэнд компанийн хувьцаа эзэмшүүлэх тухай

Монгол Улсын хэмжээнд 2011 оны 2 дугаар сарын байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн санд нийт 2,785,194 иргэн бүртгэлтэй байгаа бөгөөд иргэний шинэчилсэн бүртгэлд 2,546,852 иргэн буюу нийт мэдээллийн санд бүртгэлтэй иргэдийн 94.6 хувь нь хамрагдаад байна. Монгол Улсын хэмжээнд 16-аас дээш насны 1,794,479, 16-аас доош насны 752,103 иргэн иргэний шинэчилсэн бүртгэлээр урьдчилсан байдлаар тоологдоод байна. Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй буюу гадаадад байгаа, бүртгэлийн зөрчилтэй 238,342 иргэн байгаа болно. Одоо эдгээр үлдсэн иргэнийг шинэчилж бүртгэх ажил явагдаж байна.

“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн нийт хувьцааны 10 хувь болох 1.5 тэрбум ширхэг хувьцааг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн нэгдсэн тоогоор тооцож хуваахад нэг иргэнд эзэмшүүлэх хувьцааны тоог гаргах боломжтой болно.

Үндэсний аж ахуйн нэгжүүдэд компанийн хувьцааг худалдах тухай

а/ Эрдэнэс-Таван толгой компани нийт 15 тэрбум хувьцаатай байхаар дүрмэндээ тусгасан бөгөөд тогтоолын дагуу нэг иргэнд 536, нэг аж ахуйн нэгжид 28123 ширхэг хувьцаа ногдож байхаар, хувьцааны нэрлэсэн үнийг 300-1000 төгрөг байхаар сонгон шалгаруулалтад

оролцсон хөрөнгө оруулалтын банкууд урьдчилсан таамаглал дэвшүүлсэн байна.⁶⁸

б/ УИХ-ын 39 дүгээр тогтоолын энэ заалтад өөрчлөлт оруулж ҮААН-дэд ноогдох 10 хувийг иргэдэд шилжүүлэх 2 хуулийн төсөл нэр бүхий УИХ-ын гишүүдээс өргөн баригдсан байгааг бүрэн эхээр нь дурдвал:

1. УИХ-ын гишүүн Я.Батсуурь нарын санаачилсан хуулийн төсөл:⁶⁹

“Үндэсний аж ахуйн нэгж” гэснийг тодорхойлсон ямар нэг хууль тогтоомж байхгүй бөгөөд хувьцааг худалдан авах эрх бүхий аж ахуйн нэгжийг ямар шалгуураар тогтоох нь тодорхой бус байна. Урьдчилсан тооцоогоор манай улс 50 гаруй мянган аж ахуйн нэгж энэхүү хувьцааг худалдаж авах эрхтэй хэмээн тооцож байна. Эдгээр аж ахуйн нэгж нь улсын төсөвт төлсөн татварын хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээгээрээ эрс тэс ялгаатай учир тэдэнд Таван толгойн хувьцааг ийм маягаар хавтгайруулан тэгшитгэж олгох нь шударга бус юм.

УИХ-ын 39 дүгээр тогтоолд зөвхөн 2010 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийг хамруулахаар заасан нь нийгмийн шударга ёсны зарчимд ч харшилж байна. Тухайлбал, 2010 оны 06-р сарын сарын 30-наас хойш байгуулагдсан хэдий ч олон зуун ажлын байр бий болгож, улсын төсөвт их хэмжээний татвар төлж, улсын эдийн засгийн өсөлтөд жинтэй хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгжүүд Таван толгойн хувьцааг худалдан авч чадахгүй ялгаварлагдана.

Ер нь аж ахуйн нэгжүүдэд Таван толгойн хувьцааг худалдах нь улс орны эдийн засгийг уул уурхайгаас улам хамааралтай болгох төдийгүй хувьцааг шударгаар хуваарилах нь ихээхэн хүндрэл, маргаан дагуулсан асуудал болох тул хувьцааг нийт иргэддээ тэгш хувааж, иргэн бүрт Таван толгойн 1072 хувьцааг үнэ төлбөргүй олгох асуудлыг энэхүү тогтоолоор шийдвэрлэж байна.

2. УИХ-ын гишүүн Одбаяр нарын санаачилсан хуулийн төсөл:⁷⁰

Монгол Улсын 53336 үндэсний аж ахуйн нэгж бүрд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 28123 ширхэг хувьцааны нэрлэсэн үнийг хэт үнэтэй тогтоовол зарим аж ахуйн нэгж нь худалдан авах санхүүгийн чадамжгүй, хэт хямд байвал нийгмийн тэгш байдал, шударга ёс алдагдах үндэстэй. Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 1000 төгрөг гэвэл нэг аж ахуйн нэгж 28.0 сая төгрөг, 300 төгрөг гэвэл 8.5 сая төгрөгийн төлбөр төлж өөрт ногдох хувьцааг эзэмшихээр тооцоо байна.

Татварын ерөнхий газрын судалгаагаар нийт аж ахуйн нэгжийн 88.02 %-ийг үйл ажиллагаа эрхлээгүй, алдагдалтай, 10 саяас доош төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд эзэлж байгаа бөгөөд нэг компанид ногдох хувьцааг 28.0 орчим сая төгрөгөөр худалдаж авах санхүүгийн чадамжтай компани багахан хувийг эзэлж байна. Мөн Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1.2.б-д “хувьцааны 10 хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдсэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр худалдах” гэж хатуу заасан нь татварын зөрчилгүй аж ахуйн нэгжийг тодорхойлоход хүндрэлтэй, манай улсын нийгэм, эдийн засгийн шилжилтийн цаг үед идэвхтэй үйл ажиллагаа явуулж, татвараа төлж байсан үндэсний аж ахуйн нэгжид хувьцаа эзэмших эрх нээгдэнэ гэвэл бас л хамрагдах үндэсний аж ахуйн нэгжийн тоо эрс буурна.

⁶⁸ Эрдэнэт –Таван толгой компанийн дүрмээс

⁶⁹ Интернет “Хуулийн төсөл” цэсээс

⁷⁰ Интернет - Хуулийн төсөл цэсээс

“Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг дээр дурдсан нэрлэсэн үнээр тогтоож, нийт хувьцааны 10 хувийг аж ахуйн нэгжүүдэд худалдах тохиолдолд дараах нөхцөл байдал үүснэ гэж үзлээ. Үүнд:

- Иргэд болон аж ахуйн нэгжүүдэд ногдох хувьцааны тоо харьцангуй зөрүүтэй байна. Нэг аж ахуйн нэгжид нэг иргэнээс 52.7 дахин их хувьцаа ногдохоор байна;
- Нэг иргэн олон тооны аж ахуйн нэгжид хөрөнгө оруулсан байна. Татварын ерөнхий газрын судалгаагаар 1 иргэн 35 аж ахуйн нэгжид, 1482 иргэн тус бүр 3 аж ахуйн нэгжид, 1 компани 53 аж ахуйн нэгжид, 54 компани тус бүр 3 аж ахуйн нэгжид тус тус хөрөнгө оруулжээ;
- Гэрчилгээтэй боловч үйл ажиллагаа эрхлээгүй, татвар төлдөггүй аж ахуйн нэгжүүд иргэдтэй харьцуулахад их хэмжээний хувьцаа эзэмших боломжтой болоод байна. Нийт аж ахуйн нэгжийн 59% -ийг үйл ажиллагаа эрхлээгүй (46.3%), алдагдалтай (12.7%) аж ахуйн нэгжүүд эзэлж байна;
- Аж ахуйн нэгж тус бүр өөрт оногдох хувьцаагаа хоёр дахь зах зээл нээгдэх хүртэлх хугацаанд худалдан авахыг санал болгон, худалдан аваагүй тохиолдолд тухайн аж ахуйн нэгжийн хувьцааг яах нь тодорхойгүй байна;
- Дээр дурдсан аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь хоёрдогч зах зээл эхлэхэд хувьцаагаа зарах магадлалтай бөгөөд энэ нь зах зээл дээрх хувьцааны нийлүүлэлтийг эрс нэмэгдүүлж зах зээлийн үнийг унагах нөхцөлийг бүрдүүлэх магадлалтай.

Үндэсний аж ахуйн нэгжүүдэд иргэдтэй адил нийт хувьцааны 10 хувийг худалдахаар шийдвэрлэсэн нь аж ахуйн нэгжид хөрөнгө оруулсан иргэд болон бусад иргэдийн хувьд хэт ялгавартай хандаж, тэгш бус хуваарилалт болох нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн шударга ёс алдагдах үндэс болох бөгөөд “Хүнийг ... нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэсэн Үндсэн хуулийн зарчимтай нийцэхгүй байна.

Иймд хувьцааны нэрлэсэн үнийг хэт өндрөөр тогтоох нь хөрөнгө оруулалтын эрсдлийг бий болгож, IPO амжилтгүй болох нөхцөлийг бүрдүүлэх тул “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны үндэсний аж ахуйн нэгжүүдэд худалдах хувийг хүчингүй болгож, иргэдэд эзэмшүүлэх хувьцаан дээр нэмж олгох нь зүйтэй гэж үзэн, УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах саналтай байна

Компанийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээл дээр арилжаалах тухай

Сонгон шалгаруулах хороо Эрдэнэс Таван Толгой компанийн хувьцааны тодорхой хэсгийг олон улсын хөрөнгийн биржид арилжаалах асуудалд зөвлөлгөө өгөх, зохион байгуулахад оролцох олон улсын банкийг шалгаруулах ажлыг хийж дуусгасан. Эдгээр банкуудаас гол зохион байгуулагч буюу спонсороор Дойче Банк (Герман), Голдман Сакс (АНУ) сонгогдов. Түүнчлэн хувьцааны борлуулалтад оролцох, зуучлах (book runner, underwriter) үүрэг бүхий бэлтгэл ажилд хамтран оролцох банкаар БиЭнПи Париба банк (Франц), Маквэри банк (Австрали) тус тус шалгарсан бөгөөд банкуудыг хэлэлцээрт урьсан. Компанийн хувьцааг олон улсын аль хөрөнгийн биржид арилжаалах шийдвэрээс шалтгаалж хувьцааны борлуулалтад оролцох, хөрөнгийн биржид зуучлах, хамтран ажиллах 1-2 банкийг тодорхой хугацааны дараа нэмж авах боломжтой гэж сонгон шалгаруулах хороо болон захиалагч үзсэн.

Банкнудыг сонгож авахдаа хувьцааг арилжаалах бүс нутгийн (тивийн) төлөөлөл, IPO хийсэн ажлын туршлага, глобал болон бүс нутгийн хөрөнгийн зах зээл дээр явуулдаг үйл ажиллагаа, ирүүлсэн санал зэргийг нь харгалзан үзсэн. Дээр дурьдсан банкууд оролцохоор санал ирүүлж байгаа нь манай улсын гадаад хөрөнгө оруулалтын орчин сайжирч байгааг харуулж байна. Сонгож авсан банк, санхүүгийн байгууллагуудтай олон улсын хөрөнгийн

биржид хувьцаагаа арилжаалах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Компанийн хувьцааны тоо, хувьцаа эзэмшүүлэх, худалдах нөхцөлтэй холбоотой зарим асуудлаар холбогдох Ажлын хэсэг Засгийн газарт танилцуулга хийхээр бэлтгэж байна.⁷¹

“Эрдэнэс МГЛ” ХХК-ийг өөрчлөн зохион байгуулах талаар

“Эрдэнэс МГЛ” ХХК-ийг Үндсэн хууль, Хүний хөгжлийн сангийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах асуудлаар Төрийн өмчийн хороон дээр төвлөрч ажиллаж байна. 2010 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрд ногдох ашгаас Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртээх, хувьцаа эзэмшүүлэх талаар загвар боловсруулж танилцуулсан бөгөөд загварыг дэмжсэн. Энэ дагуу Ажлын хэсэг байгуулж Эрдэнэс МГЛ ХХК-ийн дүрэм, бүтцийг шинэчлэх, холбогдох бусад саналыг боловсруулж байгаа бөгөөд анхны хувилбар төслүүдийг боловсруулаад байна.

“Эрдэнэс МГЛ” ХХК-ийг энэ оны эхний улиралд багтаан өөрчлөн зохион байгуулж, тус компанийн давуу эрхийн хувьцааг Хүний хөгжлийн сангийн хуулийн дагуу нийт иргэдэд эзэмшүүлэх болно. Ингэхдээ иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн, бүртгэлийн зөрчилгүй Монгол Улсын нийт иргэнд компанийн давуу эрхийн хувьцааг эзэмшүүлэх болно. Нэг иргэнд эзэмшүүлэх давуу эрхийн хувьцааны тоо, үнийг сонгон авсан зөвлөх банктай зөвшилцөж, УИХ, Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлнэ

Стратегийн буюу гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой компани/ консорциум шалгаруулах талаар:

УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дээрх заалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Ерөнхий сайдын захиралжаар 2010 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан. Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэж Таван толгой ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой компани (консорциум)-ийг сонгох урьдчилсан шалгаруулалтыг олон улсын хэмжээнд нээлттэй зарлаж, зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороо, урьдчилсан сонгон шалгаруулалтын баримт бичгийг Төрийн өмчийн хорооны 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар баталсан.

Таван толгойн нүүрсийг хөрш орны болон бүс нутаг, олон улсын зах зээлд гаргах хэрэгцээ шаардлага, УИХ-ын тогтоолын заалтын дагуу Таван толгой ордын Цанхийн талбайн баруун хэсэг, Бор тээгийн нүүрсний талбайн зарим хэсгийг багтаасан талбайд нүүрс олборлох, түүнчлэн бүтээгдэхүүн борлуулалт болон орд ашиглах, бүтээгдэхүүн тээвэрлэхтэй холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөлд хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой нэгдсэн компани /консорциум/-ийг сонгон шалгаруулах урьдчилсан сонгон шалгаруулалтыг 2010 оны 12 дугаар сарын 8-ны өдөр нээлттэй зарласан. 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр оролцогчдын материалыг хүлээж авсан.

Энэ шалгаруулалтад уул уурхайн олборлолт, бүтээгдэхүүний борлуулалт, үйлдвэрлэл, тээвэрлэлтийн асуудлаар олон улсад нэр хүнд бүхий тэргүүлэгч, том компаниуд, түүнчлэн хөрш орнуудын компани, нийт 15 компани/консорциум оролцохоор санал ирүүлсэн. Оролцогчдын ирүүлсэн материалд үнэлгээний хороо үнэлгээ хийсэн бөгөөд үнэлгээний дүнд Пибоди Энержи (АНУ), Шинхуа Энержи болон Мицуи, компаниудын консорциум (БНХАУ, Япон), Оросын Төмөр Зам болон Японы консорциум, Өмнөд Солонгосын

⁷¹ Өдрийн шуудан сонин 2011,10,13ны өдрийн дугаараас

компаниудын консорциумуудын нэгдэл (ОХУ, Япон, Өмнөд Солонгос), Экстрата Коул (Австрали-Швейцарь), Валэ (Бразил), АрселорМитал (Люксембург) зэрэг 6 компани/ консорциум хураангуй жагсаалтад багтсан.

Энэ зургаагаас гурван консорциум нь бидний тавьсан нөхцлүүдийг зөвшөөрсөн болохоор АНУ-ын Пибоди 24, Хятадын “Шиньхуа” 40, Оросын төмөр зам Япон, Солонгостой нийлээд 18 хувь эзэмшихээр болж Монгол улс өөрөө “Эрдэнэс MGL “-ээ 18 хувьд нь оруулах юм. Ийм ерөнхий тоон дээр тохиролцож нөгөө талууд маань зөвшөөрсөн учраас ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж төслийг ҮАБЗ-д хүргүүлээд байна. Ингэж хэлэлцээд ҮАБЗ-д хэлэлцээд санал онол гарвал ЗГ дахин хэлэлцээд ҮАБЗ-д танилцуулахаар бэлэн болсон

Эрдэнэс таван толгой компани Зүүн цанхийн олборлогчийн тендерт ялсан Германы “Би Би Эм оперта”, Австралийн “Макмахон” тай 5 жилийн хугацаатай 500 сая ам, долларын гэрээ байгууллаа.

1. УИХ БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ХИЙГДСЭН АЖЛУУД

Стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн нүүрсний ордыг ашиглах асуудлаар Улсын Их Хурал 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 39 тоот тогтоол баталсан билээ. Уг тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газар Таван толгой ордыг ашиглахтай холбоотой асуудлыг олон удаа хэлэлцэж холбогдох тогтоол, шийдвэр гаргасан. Таван толгой ордоос нүүрс олборлох, бүтээгдэхүүн борлуулалт, тээвэрлэлттэй холбоотой зарим ажлууд хийгдэж эхэлсэн бөгөөд Таван толгой төслийн цахилгаан эрчим хүчний хангамж, усны хангалт, баяжуулах үйлдвэр зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой бэлтгэл ажлууд хийгдэж эхлээд байна.

Уурхай, олборлолтын ажлын талаар

Эрдэнэс МГЛ ХХК нь Таван толгой ордын Цанхийн зүүн хэсгийн талбайд 2010 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Эрдэнэс-ТТ уурхай байгуулах уулын ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ ажлыг Эрдэнэс Таван толгой охин компани байгуулан уурхайн ашиглалтын ажил толгой компаниас охин компанид шилжээд байна. Одоогоор Эрдэнэс Таван толгой компанийн уурхай болон хотхоны ажилчид нийлсэн 150 гаруй ажиллагсад 2-3 ээлжээр ажиллаж байна. 2011 оны 9 дүгээр сарын эхний байдлаар 2 700 000 м³ уулын цулын ажил хийж гүйцэтгэсэн ба ингэснээр сайн чанарын коксжих нүүрсний давхаргад хүрч нүүрсний олборлолт эхэлсэн.

Уурхайн олборлолтын ажлыг шинэ үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд ашиглан батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаа бөгөөд олборлолтын хэмжээгээ жил бүр нэмэгдүүлж 3-4 жилд багтаан 15 сая тонн нүүрс олборлох ил уурхай байгуулахыг зорьж ажиллаж байна.

Нүүрсний экспорт, борлуулалтын талаар

Таван толгой ордын нүүрсийг хөрш орны болон бүс нутаг, олон улсын зах зээлд гаргах хэрэгцээ шаардлагын үүднээс Эрдэнэс Таван толгой уурхайгаас 2011 оны 8 дугаар сарын 4-ны өдөр анхны нүүрсний экспортыг эхлүүлсэн. Эрдэнэс Таван толгой уурхайгаас 300,000 тонн нүүрс олборлоход бэлэн болгоод байна. Одоогоор уурхайн агуулахад 70,000 тонн нүүрсийг ачиж экспортлох ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд Цагаан хадны гаалийн хяналтын талбайд 20,000 тонн нүүрсийг тээвэрлэж хүргээд байна.

Эрдэнэс МГЛ ХХК болон Эрдэнэс Таван толгой компани Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Хүний хөгжил санд төвлөрүүлэх мөнгийг нүүрсний урьдчилсан борлуулалтын орлого хэлбэрээр бүрдүүлэх,

Таван толгойн нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлын хүрээнд БНХАУ-ын төрийн өмчийн Чиналко (Aluminum Corporation of China) компанийн 100%-ийн борлуулалт эрхэлдэг Чалко (China Aluminum International Trading) компани, Хятадын Хэбей мужийн Жинан стийл интернэйшнл компанитай нүүрс борлуулалтын гэрээг 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан. Энэхүү нүүрс борлуулалтын гэрээний хүрээнд Эрдэнэс Таван Толгой компани нь жилд олборлох нүүрсний 80 хувийг Хятадын зах зээлд болон эцсийн хэрэглэгч болох гангийн үйлдвэрт болон гуравдагч орны буюу Япон, Өмнөд Солонгосын зах зээлд борлуулах боломжтой болж байна. Мөн нүүрсний экспортын үнийг өндөр байлгах зорилгоор олон улсын нүүрсний индексийн дагуу улирал болгон шинэчлэн тогтоох механизмыг гэрээнд оруулж өгсөн болно.

Таван толгойн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх талаар

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Эрдэнэс МГЛ ХХК-ийн эзэмшиж байгаа Тавантолгойн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг түүний охин компани Эрдэнэс Тавантолгой ХК-д шилжүүлэхдээ бүтээгдэхүүн гаргахад бэлэн байгаа Цанхийн талбайгаас эхлэх, бусад хэсгийг нэмэлт хайгуул, судалгаа хийсний үндсэн дээр шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Эрдэнэс МГЛ ХХК нь Таван толгой ордын бүтээгдэхүүн гаргахад бэлэн байгаа буюу Цанхийн талбайг хамарсан тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу Эрдэнэс Таван толгой ХК-д эхний ээлжинд шилжүүлсэн болно.

Таван толгой нүүрсний ордын Оорцог, Онч хараат, Бортээгийн зарим хэсэг, Бор толгойн нүүрсний талбайнуудад хийгдсэн геологи хайгуулын үр дүнгийн тайланд тулгуурлан, нөөцийг шинэчлэн тооцож, ЭБМЗ-р хэлэлцүүлэн улсын нөөцөд шинэчлэн бүртгүүлэхтэй холбогдсон нэмэлт ажил хайгуул судалгаа хийхэд тодорхой хугацаа шаардлагатай байгаа тул эдгээр талбайд хийгдсэн нарийвчилсан хайгуулын үр дүнгийн тайланд нөөцийн тодотгол судалгаа хийж, шилжүүлэхээр ажиллаж байна.

Гэрээт олборлогч (оператор) компанийн талаар

Таван толгой ордын Цанхийн зүүн хэсэг буюу Эрдэнэс-ТТ уурхайд гэрээгээр олборлолтын ажил гүйцэтгэх гэрээт олборлогч (оператор) компанийг сонгох тендер шалгаруулалтыг дотоод, гадаадад нээлттэйгээр зарласан. Үнэлгээний хороо тендерт оролцогчдын ирүүлсэн материалыг хууль, журмын дагуу үнэлж, шийдвэр гаргасан.

Тендерт оролцогч Австралын Макмахон Лимитед, Германы БиБиЭм Оперта компаниуд Эрдэнэс Таван толгой уурхайд гэрээгээр олборлолтын ажлыг хамтран гүйцэтгэхээр санал ирүүлсэн. Эрдэнэс Таван толгой компанийн ТУЗ нь дээрх компаниудтай УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолд заасан үндсэн зарчмын дагуу тодорхой хугацаанд Эрдэнэс таван толгой уурхайн буюу Цанхийн зүүн талбайд гэрээт олборлогчийн (оператор) ажил гүйцэтгэхтэй холбоотой хэлэлцээ хийх шийдвэр гаргасан болно. Энэ дагуу Эрдэнэс Таван толгой компани хэлэлцээ хийж эхэлсэн ба ойрын хугацаанд хэлэлцээг дуусгаж, олборлогч (оператор) компанитай гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэхээр төлөвлөж байна.

Компанийн хувьцаа болон хөрөнгийн зах зээл дээр гарахтай холбоотой ажлын талаар

Таван толгой ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах Эрдэнэс Таван толгой компанийн хувьцааг нь иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх, худалдах, гадаад, дотоодын хөрөнгийн зах зээл дээр арилжаалах (IPO) бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу дэс дараатайгаар хийж байна.

Засгийн газрын 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар Эрдэнэс Таван толгой компанийн хувьцааны 10 хувийн хувьцааг 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээс өмнө төрсөн Монгол Улсын иргэнд эзэмшүүлэх тухай шийдвэрийг гаргасан. Ингэснээр Монгол Улсын иргэн компанийн 536 ширхэг хувьцаа эзэмшигч болох боломжтой болсон. Мөн хуралдаанаар “Эрдэнэс Таван толгой” компанийн хувьцааг хоёр дахь зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн шийдвэр гаргасны дараа иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлсэн хувьцааг нийтэд арилжаалах ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын иргэн бүрийн нэр дээр Эрдэнэс Таван толгой компанийн 536 ширхэг хувьцаа эзэмших үнэт цаасны бүртгэлийн ажил хийгдэж байна. Монгол Улсын иргэн энэхүү бүртгэлийн ажилтай холбоотой мэдээллийг Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн <http://www.schcd.mn/> гэсэн цахим хуудсанд хандаж мэдэх боломжтой болсон.

Эрдэнэс Таван толгой компанийн хувьцааны 10 хувийг шаардлага хангасан үндэсний аж ахуйн нэгж тус бүрт тэнцүү хэмжээгээр нэрлэсэн үнээр санал болгон худалдах болно. Татварын ерөнхий газрын мэдээгээр 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө байгуулагдаж анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлж, санхүү аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргасан нийт 53336 үндэсний аж ахуйн нэгж байгаа бөгөөд энэ тохиолдолд нэг аж ахуйн нэгжид 28123 ширхэг хувьцаа ногдохоор урьдчилсан тооцоог хийгээд байна.

Хувьцаа худалдан авах үндэсний аж ахуйн нэгжийг ямар шалгуураар тогтоох нь төдийлөн ойлгомжтой бус, ахуйн нэгжид хувьцааг худалдах нь нийгмийн тэгш байдал, шударга ёсны талаар гомдол, маргаан гарах, эдийн засаг хэт уул уурхайгаас хамааралтай байдал бий болох зэрэг үндэслэлээр үндэсний аж ахуйн нэгжид худалдах хувьцааг нийт иргэддээ тэгш хувааж, иргэн бүрд 1072 ширхэг хувьцаа эзэмшүүлэх тухай УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолыг төслийг зарим гишүүд санаачилсан байна. Эрдэнэс Таван толгой компанийн хувьцааны нэрлэсэн үнэтэй холбоотой асуудлаар сонгон авсан зөвлөх компанитай хамтран холбогдох саналыг боловсруулж байна.

Эрдэнэс-Таван толгой компанийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн биржид арилжаалахтай арилжаалах бэлтгэл ажлууд хийгдэж эхэлсэн бөгөөд компанийн хувьцааг олон улсын аль хөрөнгийн биржид арилжаалах судалгаа, телеконференц болон уулзалтыг тогтмол хийж байна. Олон улсын хөрөнгийн бирж дээр компанийн хувьцааг арилжаалах ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа бөгөөд банкууд болон аудитор, хуулийн зөвлөхүүдтэй хамтран компанийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж (МХБ), Лондонгийн Хөрөнгийн Бирж (ЛХБ) болон Хонг Конгийн Хөрөнгийн Биржүүд (ХКХБ) дээр гурвалсан аргаар бүртгүүлэх бүтцийг урьдчилсан байдлаар гаргаж энэ асуудлаар шаардлагатай судалгааны ажил хийгдэж байна. Түүнчлэн компанийн хувьцааг олон улсын хөрөнгийн бирж дээр арилжаалах ажил төлөвлөгөөний дагуу дараах ажлууд хийгдэж байна:

- Ордын нөөцийг олон улсын стандартаар тооцоолон гаргах;
- Компанийн засаглал, үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийг олон улсын шаардлага стандартад нийцүүлэх;
- Олон улсын аль хөрөнгийн биржид гарах бүтцийг тодорхойлох;
- Хөрөнгө оруулагчдад танилцуулах, танилцуулга “проспектус” боловсруулах;
- Санхүүжилтийн (Bankable) Техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгах гэх мэт.

Цаашид олон улсын хөрөнгийн биржид хувьцаа гаргах зөвшөөрөл авах, хувьцааны арилжааны сурталчилгаа, танилцуулга (roadshow) хийх зэрэг олон ажлууд хийгдэхээр төлөвлөгдөж байгаа бөгөөд компанийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргахад нөлөөлөх хүчин зүйлүүд болох IPO-д зориулсан судалгаа хийх, уурхайн болон нүүрс тээвэрлэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, гэрээт олборлогчийг сонгох зэрэг чухал ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар

Засгийн газраас Таван толгой төслийн цахилгаан эрчим хүч, усан хангамжтай холбоотой асуудлаар шаардлагатай зөвшөөрлийг Эрдэнэс МГЛ болон Эрдэнэс Таван толгой компанид олгохоор шийдвэрлэсэн. Тавантолгой төслийн хүрээнд шаардагдах эрчим хүчний хангамжийг шийдвэрлэх зорилгоор Тавантолгойн ордыг түшиглэн 600 МВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станц барих асуудлыг судлах, урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил хийгдэж эхлээд байна.

Одоогоор Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн барих цахилгаан станцын урьдчилсан ТЭЗҮ бэлэн болсон бөгөөд хоёр талын ажлын хэсэг уг ТЭЗҮ болон судалгааг Оюутолгой төслийн талбайд барих цахилгаан станцын ТЭЗҮ -тэй харьцуулалт хийн дүгнэлт гаргаж, цахилгаан станцын байршлыг сонгохоор ажиллаж байна. Энэхүү цахилгаан станц нь Оюутолгой болон Тавантолгой төслийн хүрээнд шаардагдах эрчим хүчний хангамж, түүнчлэн говийн бүсийн эрчим хүчний асуудлыг шийдвэрлэхэд голлох үүргийг гүйцэтгэх юм.

Таван толгой уурхайд жилдээ дунджаар 8.5 сая тонн коксжих нүүрс, 3.7 сая тонн эрчим хүчний нүүрс, 1 сая тонн завсрын бүтээгдэхүүн, нийтдээ 15 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадал бүхий угаах, боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөн холбогдох бэлтгэл ажлыг мөн эхлүүлсэн. Үүнтэй холбоотойгоор холбогдох байгууллагаас хуульд заасан хугацаа, нөхцөлөөр ус ашиглах зөвшөөрөл авах хүсэлтээ гаргаад байна.

Стратегийн буюу гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой компани/ консорциум шалгаруулах талаар

Таван толгой ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой компани (консорциум)-ийг сонгон шалгаруулах шийдвэр гарч, уг сонгон шалгаруулалтыг 2010 оны 12 дугаар сараас 2011 оны 2 дугаар сарын хооронд зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтанд уул уурхайн олборлолт, бүтээгдэхүүний борлуулалт, үйлдвэрлэл, тээвэрлэлтийн асуудлаар олон улсад нэр хүнд бүхий, тэргүүлэгч том компаниуд болон хөрш орнуудын, дотоодын нийт 15 компани, консорциум оролцсоноос 6 оролцогч шалгарч үлдсэн.

Эдгээр оролцогчтой УИХ-ын 39 дүгээр тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Ерөнхий сайдын захирамжаар баталсан удирдамжийн дагуу дамжин өнгөрөх тээвэр, боомт ашиглалт, борлуулалт, хөрөнгө оруулалтын нөхцөл, урьдчилгаа төлбөр зэрэг асуудлаар хэлэлцээ хийж эхэлсэн. Хэлэлцээний багийн ахлагчаар Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар ажиллаж байгаа бөгөөд 2011 оны 3 дугаар сараас эхлүүлэн хураангуй жагсаалтад багтсан компани, консорциумтай хэлэлцээ хийж эхэлсэн ба хэлэлцээ үргэлжилж байна.

Хэлэлцээний явцад орд ашиглах хувилбарын хүрээнд нүүрсний борлуулалт, урьдчилгаа төлбөр, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, байгаль орчинд ээлтэй технологи, нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах санал, ордыг түшиглэсэн үйлдвэр, барилга байгууламж, дэд бүтэц, зам барьж байгуулах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах, Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд авч хэрэглэх нөхцөл болзлыг хэрэгжүүлэх үндсэн асуудлыг тусгасан хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулсан.

2011 он бол Таван толгой ордыг ашиглаж эхлэх үйл ажиллагааны гол жил бөгөөд тус ордоос эхний ээлжинд 2 сая хүртэл тонн нүүрс олборлож экспортлох, төслийн санхүүжилтийг босгох, гэрээт олборлогч компани болон стратегийн хөрөнгө оруулагчийг сонгох, олон улсын банкууд болон аудитор, хуулийн зөвлөхүүдтэй хамтран Эрдэнэс Таван толгой

компанийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн биржид арилжаалах бэлтгэл ажлыг хангах, усны хангамж, баяжуулах үйлдвэр байгуулах, уурхайчдын орчин үеийн хотхон барих, цахилгаан станц, авто замын зэрэг их бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх чухал жил юм.

1. ТАВАН ТОЛГОЙ ОРДЫГ АШИГЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ЗАРЧИМ, ХЭРЭГЖИЛТ

Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн зарчим бол “Тогтвортой хөгжлийг бий болгох”-д чиглэх ёстой. Өөрөөр хэлбэл, гэрээний жижиг заалтуудыг авч үзэхгүйгээр тухайн хөрөнгө оруулалтын гэрээ нь

- Хөрөнгө оруулалт урт хугацаанд өгөөжөө тогтвортой өгөхийн тулд юу хэрэгтэй вэ? Хөрөнгө оруулалтын гэрээнд урт хугацаанд юуг тогтвортой барих вэ? гэсэн суурь асуудлыг шийдвэрлэхэд “үндсэн зарчим, үзэл баримтлал” чиглэх ёстой юм. Уул уурхайн ажил бол урт хугацаанд үйл ажиллагаа явуулдаг, зардлаа нөхөх хугацаа урт байдаг онцлогтой. Хөрөнгө оруулалтын гэрээнд оролцогч талууд харилцан өөрийн ашиг сонирхлоо хамгаалах хэрэгцээ үүснэ. Тэгэхээр хөрөнгө оруулагч тал болон төрийн хооронд хөрөнгө оруулалтын гэрээгээр гүйцэтгэж байгаа ажил “Харилцан ашигтай байх” нь хамгийн гол суурь юм.

Уул уурхайн төслүүдэд хөрөнгө оруулагчид нь ихэвчлэн улсын том компаниуд байдаг. Иймэрхүү үйлдвэрийн газрын удирдлагын гол анхаардаг зүйл нь хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн үнэ цэнэ болон хөрөнгө оруулалтын өгөөжийг тогтвортой, дээд хэмжээнд байлгах явдал юм. Үүнтэй холбоотойгоор бодитой болон байж болох эрсдэлийг удирдах нь удирдлагын гол үүрэг болдог. Эрсдлийг удирдах нь ихэвчлэн өөр өөр оронд өөр өөр төрлийн баялагт хөрөнгө оруулалт хийх замаар хэрэгждэг. Ингэхдээ хөрөнгө оруулагчид нь санхүүгийн орчин нь таатай бөгөөд тогтвортой гэж үзсэн орныг бусад техникийн үзүүлэлтүүдтэй нь харьцуулсны үндсэн дээр сонголтоо хийдэг байна.

Засгийн газрын зүгээс анхаардаг зүйлс нь ихэвчлэн орлого бий болгох, ажлын байр бий болгох, нийт эдийн засгийн өсөлт болон эдгээр зорилгод тухайн салбарын оруулж буй хувь нэмэр байдаг. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах нь богино болон урт хугацаанд үр нөлөөгөө үзүүлдэг гэж ихэнх Засгийн газар үздэг. Удаах хүчин зүйлс нь төслийн нийт эдийн засагт үзүүлэх нөлөөг байж болох дээд хэмжээнд хүргэх явдал юм. Тухайн салбарын гэрээнүүдийн эдийн засагт бүхэлд нь нөлөөлөх нөлөөлөл түүний урт хугацааны үр дагаварыг тооцох хамгийн чухал гэдгийг Засгийн газар анхаарах ёстой.

Хөрөнгө оруулагч компаниуд нь аль илүү өндөр хүлээгдэж буй өгөөжтэй, хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд эрсдэлтэй төслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг байна. Тэдгээр төслүүдийг үнэлэхдээ харж үздэг хүчин зүйлүүдэд тухайн орны санхүүгийн орчин, мөн төсөлтэй холбогдох техникийн, санхүүгийн, зах зээлийн болон улс төрийн эрсдэлүүд, түүнчлэн уг төсөлтэй өрсөлдөгч бусад төслүүд болон санхүүжилийн хязгаарлалт зэрэг багтана. Өнөөгийн Монгол улсад хөрөнгө оруулалт хийж байгаа компаниудын хөрөнгө оруулалт хийж байгаа хандлагаас харахад манай улсад дараах давуу байдлууд байна гэж үздэг.

- Хятадын зах зээлд хамгийн ойр
- Хэдий дэд бүтэц сул хөгжсөн ч түүнийг шийдвэрлэхэд газар зүй, орчны нөлөөлөл, хүндрэл багатай, зардал бага байх бүрэн боломжтой
- Хэдий эрх зүйн зохицуулалт тогтворгүй ч улс төр, нийгмийн орчин харьцангуй тайван орны тоонд ордог
- Ажиллах хүчний зардал хямд, гадаадын хөрөнгө оруулалтад таатай ханддаг

Уул уурхайн зөвлөгөө өгдөг Бехре Долбейр компани уул уурхайн хөрөнгө оруулалт хийхэд тааламжтай болон тааламжгүй улс орнуудын жагсаалт хийдэг бөгөөд энэ нь нэг ёсондоо

Судалгааны эмхтгэл, XI боть

уул уурхайн хөрөнгө оруулагчдын гарын авлага болдог байна. Тус компани 1999 оноос хойш энэхүү жагсаалт-үнэлгээг гаргаж байгаа бөгөөд жагсаалтыг гаргахад улс орнуудын эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, нийгэмд тулгарч буй хүчин зүйлс, нэн ялангуяа тухайн улс орны уул уурхайд нөлөөлж байгаа нийгмийн хүчин зүйлс, уул уурхай, ашигт малтмалтай холбоотой зөвшөөрөл өгөх авах, авилгал, хээл хахууль, мөнгөний нэгжийн тогтвортой байдал болон татварын систем голлох үүрэг гүйцэтгэдэг буюу нэг ёсны шалгуур үзүүлэлт болдог байна.

Бехре Долбейр 2011 онд ямар улсад хөрөнгө оруулаад хэрэггүй вэ гэсэн ээлжит зөвлөмж-судалгаагаа гаргажээ. Судалгаанд нийт таван тивийн 25 орон хамрагдсаны дотор Монгол улсыг мөн авч үзжээ. Судалгаанаас үзвэл Монгол улс 2004-2005 онуудад дээрх 25 орноос 11-т жагсаж байсан бол 2006 онд хоёр нэгжээр дээш ахиж 9-р байранд оржээ. Хөрш орнуудын хувьд Хятад 10-р (2011 онд 13-14) байранд, Орос улс 19-т (2011 онд 25) байсан байна. Тэгвэл энэ 2011 онд манай улс 2010 оныхоос 2 нэгж уруудаж 9-10 дугаар байрыг Гана улстай хуваан эзэлжээ.

BEHRE DOLBEAR'S 2011 RANKING OF COUNTRIES

2011 Rank	Country	Economic System	Political System	Social Issues	Permitting Delays	Corruption	Currency Stability	Tax Regime	2011 Total Points	2011 Change versus 2010
1	Australia	9	8	8	8	10	9	5	57	-4
2	Canada	9	9	4	4	10	9	7	52	-4
3	Chile	9	9	7	6	8	8	4	51	+2
4	Brazil	7	8	5	5	5	9	6	45	+3
5	Mexico	8	8	2	7	6	6	7	44	-1
6	United States	8	9	3	1	10	7	3	41	-1
7	Colombia	6	7	6	6	5	5	4	39	0
8 TIE	Botswana	6	5	5	5	5	5	6	37	+1
8 TIE	Peru	6	6	4	4	5	7	5	37	+4
10 TIE	Ghana	6	5	2	6	3	6	6	34	-2
10 TIE	Mongolia	6	6	5	5	2	6	4	34	-2
12	Tanzania	5	5	3	7	3	4	5	32	0
13 TIE	China	6	1	3	5	3	8	5	31	-4
13 TIE	Namibia	4	5	3	5	3	5	6	31	0
15 TIE	Argentina	5	3	4	6	4	4	4	30	-1
15 TIE	India	6	6	2	3	3	6	4	30	+1
17	Philippines	5	5	3	5	2	4	4	28	+2
18	Indonesia	5	6	4	3	2	3	4	27	+6
19 TIE	Zambia	5	4	3	5	2	2	3	24	+1
19 TIE	South Africa	3	4	2	5	2	6	2	24	+1
21 TIE	Kazakhstan	3	3	4	3	1	4	4	22	-2
21 TIE	Papua New Guinea	4	4	1	2	2	4	5	22	0
23	D.R. Congo	3	3	3	3	2	1	4	19	0
24	Bolivia	2	1	1	4	3	3	3	17	-1
25	Russia	1	1	3	3	1	2	5	16	-3

Уг тайланд дурьдсанаар Монгол Улс авилгын асуудлаа шийдвэрлэх талаар ахиц сайн гараагүй болон орон нутгийн иргэд, ТББ-ууд хөрөнгө оруулагчдад эсэргүүцэл үзүүлж тэмцлээ идэвхжүүлж байгаа зэргээс шалтгаалж ухарсан гэдгийг тэмдэглэжээ.

Эдгээр судалгаа дүгнэлтээс харахад манай орон хөрөнгө оруулах таатай нөхцөлтэй, ашигтай орнуудын тоонд багтаж байна. Тэгэхээр эдгээр орнуудын Засгийн газар хөрөнгө оруулалтын гэрээнд илүү давуу байр суурьтай орох боломжтой буюу хөрөнгө оруулагчид ямартай ч ашигтай ажиллах боломжтой гэдэг байр суурь баримтлах магадлалтай. “Монгол улс бол хөрөнгө оруулахад таатай орон. Түрүүлж буусан шувуу илүү ихийг хүртдэг гэдгийг биеэрээ мэдэрсний хувьд та бүхнийг Монголд хөрөнгө оруулахыг уриалж байна.” Энэ үгийг Монголд хөрөнгө оруулалт хийж, бизнес эрхлээд 12 жил болж байгаа “Монголиан Стар Мелшерс” компанийн захирал Лоренц Мелшерс “Дисковери Монголиан 2010” хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын индрээс хэлсэн юм.

Тэрбээр хөрөнгө оруулагчдыг төлөөлөн тавьсан илтгэлдээ “Өнөөдөр Монголын уул уурхайн хангамжийн бүхий л салбарт хөрөнгө оруулах орон зай эзнээ хүлээсээр байна” гэв. Энэ үгийг нэгэн компанийн захирлын үг гэлгүйгээр Монголд хөрөнгө оруулалт хийж, үр шимийг нь хүртсэн олон зуун хөрөнгө оруулагчдын үг гэж ойлгож болох юм.

Монгол улсын эдийн засаг ойрын жилүүдэд огцом өснө гэдгийг дотоод гадаадын олон байгууллага, судлаачид хэлж байгаа. 2020 он хүртэлх хугацаанд манай улсын эдийн засаг 14-15 хувиар өсч, ДНБ-ий хэмжээ Малайз, Индонез, Тайванийн түвшинд очих боломжтой гэсэн таамгийг мэргэжлийн байгууллагууд дэвшүүлсэн байна. 2020 онд нэг хүнд ногдох ДНБ 12 мянган ам.доллар болж, 2021 он гэхэд улсын ДНБ-ий хэмжээ 41 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн өөдрөг төсөөллийг Засгийн газраас гаргаад байгаа.

Ийм нөөц бололцоо бий гэдгийг гадаадын мэргэжилтнүүдийн таамаг ч баталж буй. Тухайлбал “Голомт” банкны Гүйцэтгэх захирал Жон Финиган хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт дээр “2016 он гэхэд Монгол улсын уул уурхайн салбарт эргэлт гарна. Хэдий хаяанд мэт бодогдовч боломжоо зөв ашиглаж чадвал Монголын эдийн засагт эргэлт хийж болох цаг хугацаа. 2016 он гэхэд зэс олборлолтын хэмжээ жилд 36 мянган тоннд хүрэх бөгөөд үүнийг 2005 онтой харьцуулахад үлэмж хэмжээний өсөлт” гэсэн юм.

Байгалийн баялаг, газрын тосоор баялаг Арабын Нэгдсэн Эмират улсын ДНБ 2.8 тэрбум ам.доллараас 230 тэрбум ам.доллар буюу 82 дахин өссөн, Катар улс ДНБ-ийхээ хэмжээг 15 жилийн дотор 12 дахин нэмсэн амжилтаараа дэлхий нийтийг гайхуулж байна. Монгол улсын эдийн засаг ч үүнтэй адил үсрэнгүй өсөлттэй байж болно. “Голдмен Сакс”-ын хийсэн судалгаанд 2050 он гэхэд АНУ зэрэг хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт саарч, дэлхийн эдийн засгийн 2/3-ыг одоогийн хөгжиж байгаа орнууд эзлэх болно хэмээн дурдсан байна. Өөрөөр хэлбэл өнөөдөр байгалийн баялгаа ашиглаж эхэлж байгаа, эдийн засгаа хөгжүүлэхээр чармайн ажиллаж буй орнууд 40 жилийн дараа дэлхийн эдийн засгийн талаас илүүг эзлэх нь байна.

Энэ бүхнийг дүгнэж үзвэл Монгол Улсад хөрөнгө оруулахад ашигтай учир хөрөнгө оруулагчид бага зэрэг эрсдлийг ч тооцохгүйгээр тэмүүлж байгаа тул манай Засгийн газар хэлэлцээрийн ширээний ард “давуу боломжтой суух буюу тоглоомын дүрмийг Монгол улс тогтооно”. Гэхдээ олон улсын өмнө хүлээсэн үүрэг, зарчмаа даган “ХАРИЛЦАН АШИГТАЙ БАЙХ” зарчмаа алдагдуулахгүй байх шаардлагатай.

Зарчмын асуудлууд

Аливаа “зарчим бол хэрэгцээнд тулгуурлан” гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, УИХ-ын 2010 оны 39-р тогтоолд тусгагдсан үзэл баримтлал, зарчмууд бол Монгол Улсын хэрэгцээ гэж үзэж болно. Эдгээрийг багцалж авч үзвэл:

- Тавантолгойн ордын ашиглалтын лицензийг төр бүрэн эзэмшиж, тухайн ордод үйл ажиллагаа явуулах “Эрдэнэс-ТТ” компаний хувьцааны 50 хувийг төрийн эзэмшилд байлгах
- Олборлосон нүүрсийг орчин үеийн технологиор боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Шаардагдах дэд бүтцийг барьж байгуулах. Энэ нь эдийн засгийн болоод экологийн ач холбогдолтой байлгах, энэ ажилд хөрөнгө оруулагчдыг татах
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид нь “Эрдэнэс-ТТ” компаний хувьцааны 50 хүртэл хувийг (30+10+10) нэгдсэн компани /консорциум/ байдлаар эзэмшиж олборлох, үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа явуулах боломжтой байх

Эдгээр зарчим бол ТТ-н ордыг ашиглах явцад тогтвортой байх үндсэн суурь асуудал, үзэл баримтлал нь болох юм. Бас нэгэн үндсэн зарчим бол Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.2.2-т “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална”

гэж заасанчлан хөрөнгө оруулагчдын оролцооны тэнцвэрийг хэрхэн хангасныг авч үзэх шаардлагатай юм.

“Харилцан ашигтай байх” зарчим гэдэг ойлголт бол зөвхөн ашиг, орлого талаасаа бус хариуцлага талаасаа ч мөн “ашигтай” байх зайлшгүй шаардлагатай. Тухайлбал, хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд “Хөрөнгө оруулагч нь Монгол Улсад бүртгэлтэй байх”-аар заасан нь өөрийн хөрөнгө багатай салбар компани сонгон шалгаруулах магадлал өндөр байна. Иймээс хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгө, ашиглах технологи, мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайг хаах талаарх үүргүүдийг толгой компани нь давхар хариуцахаар баталгаажуулах асуудлыг гэрээнд тусгах нь зүйтэй юм⁷². Ингэснээр хөрөнгө оруулагч талын хариуцлагын асуудал өндөрсөх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Судлаачид, уул уурхайн мэргэжилтнүүд одоогийн мөрдөж байгаа Ашигт малтмалын хуулийн болон энэхүү 39 дүгээр тогтоолыг мөрдөхөд санаа нь хоёрдмол байна гээд олон олон заалтуудыг жишээ болгож тайлбарладаг. Үг зүй, найруулга талаасаа яаж тайлбарлаж байгаагаасаа шалтгаалж олон үндэслэлүүдийг гаргаж ирж болох ч дээр дурьдсан үндсэн зарчмыг баримтлах нь түлхүүр асуудал болж байна.

Засгийн газрын стратегийн хөрөнгө оруулагчидтай хийж байгаа хэлэлцээрээр тус ордын Цанхийн хэсгийг үндсэн 2 хэсэгт хувааж үйл ажиллагааг нь явуулахаар төлөвлөж байна. Бизнесийн утгаараа, төр нь аль ч цаг үед “хамгийн муу менежер”-ээр шалгарч явж ирсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хувьцаат компанид төр 50 хувь эзэмшинэ гэдэг бол цаад утгаараа “менежментийг өөрөө хийнэ” гэсэн үг.

Үүнээс гарах гарц нь Баруун Цанхийн хэсэгт үйл ажиллагаа явуулах стратегийн хөрөнгө оруулагчид “Уурхайн асуудлыг хэрхэн шийдэх, тоног төхөөрөмж, борлуулалтаа яаж хийх, уурхайтай холбоотой дэд бүтцийн асуудал буюу нүүрс угаах үйлдвэр, цахилгаан станц, усны хангамжийн системд яаж оролцох, байгаль орчны нөхөн сэргээлт, ажилтнуудын сургалтын асуудал, хөдөлмөрийн аюулгүй байдал зэргийг шийдэх эрхийг” олгож байгаа⁷³ нь уурхайн менежментийг сайн хийх боломжийг олгож байгаа явдал гэж үзэж болох юм.

Гэхдээ, УИХ-ын тогтоолд “2/Таван толгойн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэс-Таван толгой” компанийн хувьцааны 50 хүртэлх хувийг Монгол Улсын иргэн, үндэсний аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх, дотоод, гадаадын хөрөнгийн биржээр арилжаалах талаар дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх ...” гэж заасан учир уг стратегийн хөрөнгө оруулагч компани (консорциум)-ий хувьцааны 50 хувийг эзэмшинэ гэдгийг тодорхой ойлгож болох юм. Харин энэ тохиолдолд “муу менежер” байхгүйн тулд түүнээс зайлсхийж хөрөнгө оруулалтын гэрээгээр менежментийг хөрөнгө оруулагч талд шилжүүлэх хувилбар гарч ирнэ. Энэ нь эргээд төрд ирэх ашгийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, олборлолт, борлуулалтаас орох ашгийг нэмэгдүүлэх хувилбар болж болох юм.

Нэг талаас төр, тухайн улсын иргэд “явал хамгийн их ашиг хүртэх вэ?” хэмээн эрмэлзэж өөрийн эзэмшлийн хувиа нэмэгдүүлэх, татвараа өсгөхийг эрмэлзэнэ. Нөгөө талаас хөрөнгө оруулагч “явал хамгийн богино хугацаанд зардлаа нөхөж ашигаа нэмэгдүүлэх вэ?” гэдэгт анхаарал хандуулна. Энэ хоёрын огтлолцол дээр “эрх ашгийн зөрчил” үүсэх нь гарцаагүй⁷⁴. Үүнийг шийдвэрлэхэд “урт хугацааны, тогтвортой, харилцан ашигтай хамтын

⁷² “Investment contracts and sustainable development - How to make contracts for fairer and more sustainable natural resource investments” Lorenzo Cotula. First published by the International Institute for Environment and Development (UK). in 2010

⁷³ <http://www.ot.mn>


⁷⁴ Investment contracts and sustainable development: How to make contracts for fairer and more sustain-

ажиллагаа” тун чухал болно.

Сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдэж, ялангуяа уул уурхайн салбарт дийлэнх нь чиглэж байна. Монгол улсад бизнес явуулахад эрсдэл ихтэй байсан бол ийм хандлага маш бага байх байсан. Үүнийг дүгнэж хэлэхдээ Монгол улсын эдийн засгийн болон улс төр нийгмийн байдлын тухай гадаадын шинжээчид “Discover Mongolia – 2011” чуулга уулзалтад оролцох үедээ “энэ 2011, 2012 онд Монгол улсад хөрөнгө оруулахад хамгийн тохиромжтой үе юм” гэж тодорхойлж байна.

Чуулганд оролцогчдын болон зохион байгуулагчид, салбарын яамдын илтгэл, дүгнэлтээр дараах зүйлс харагдаж байна. Үүнд:

- Татварын хэмжээ хэд байх нь Монгол Улсын дотоод асуудал: Гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол улсын уул уурхайн салбарын татварын хэмжээ хэд байх нь “хамааралгүй” буюу онцын чухал асуудлын хэмжээнд авч үзэхгүй байна гэж болохоор байна. Угаас, манай улсын орлогын албан татварын хэмжээ шинэчилсэн түвшингээрээ Азид төдийгүй, дэлхийн хэмжээнд бага татвартай орны тоонд орж байгаа юм. Уул уурхайн салбарын татварын хэмжээ дэлхийн дундаж нь 28% орчим байгаа бол манайх дээд тал нь 25% байгаа нь үүнийг гэрчилж байна. (Дор хүснэгтэд үзүүлэв)



able natural resource investments. Lorenzo Cotula. First published by the International Institute for Environment and Development (UK) in 2010

Ази болон Австралийн бүсийн орлогын албан татварын харьцуулалт⁷⁵:

Улсын нэр	Орлогын албан татварын хувь		НӨАТ
	Аж ахуйн нэгж	Хувь хүн	
Australia	30%	17-45%	10%GST
China	25%	5-45%	17%
India	30-40%	10-30%	12.50%
Indonesia	28%	5-30%	10%
Japan	30%	5-50%	5%(consump)
New Zealand	30%	0-39%	15%gst
Pakistan	35%	0-25%	15%
Philippines	30%	5-32%	12%
Thailand	30%	5-37%	7%
Vietnam	25%	5-35%	10%
AVAREGE	28%		

(Last partial update, August 23, 2011)

- Ашигт малтмалын хууль эргэлзээ төрүүлдэггүй, “цор ганц” байх хэрэгтэй: Монгол улсын хууль, эрх зүйн орчин тогтвортой байх л хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, “Монгол улсын хууль нь цор ганц, тогтвортой байж” чадвал хөрөнгө оруулагчид Монголд хөрөнгөө оруулахад эрсдэл буурч, өндөр сонирхлыг бий болгож байна. УУҮА-ийн гүйцэтгэх захирал Н.Алгаагийн тодорхойлсноор гадаадын хөрөнгө оруулагчид ердөө хоёр л зүйлийг Монгол Улсын төрөөс хүсэж байна. Энэ нь “1. Тогтвортой байдал, 2. Тодорхой байдал” Энэ 2 үгээр хүсэлт, хандлагын санааг бүрэн илэрхийлэх боломжтой гэж үзэж байна.
- Хөрөнгө оруулагчдын хувьд “уул уурхайн салбарын анхны хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр, үйл ажиллагаа зогслоо гэхэд түүнийг буцаан авах боломжгүй байдаг, зардлаа нөхөх хугацаа урт байдал, эрх зүй, татварын орчин тогтвортой байх баталгааг гаргаж чадахгүй” гэсэн байр суурийг аль ч төрлийн компани, хөрөнгө оруулагч илэрхийлж байдаг учраас тогтвортой, тодорхой байдлыг төрөөс хүсэж байдаг.
- Экологийн хувьд хөнгөлөлт үзүүлэхгүй байх: Монгол улсын хувьд “хөрөнгө оруулагчидтай аливаа нөхцөл, хувилбарыг хөрөнгө оруулалтыг хэлэлцсэний үндсэн дээр тохирч аль аль талаасаа хөнгөлөлт үзүүлэх, тохиролцоо асуудал байж болно. Гагцхүү, экологийн асуудлаар ямар ч хөнгөлөлт, чөлөөлөлт байхгүй” гэдгийг хөрөнгө оруулагчдад анхааруулсан бөгөөд үүнийг тэд бүрэн хүлээн зөвшөөрсөн байдаг⁷⁶. Зөвшөөрч ярих нэг асуудал, хэрэгжүүлэх бас өөр асуудал. Ярьсны дагуу хэрэгжүүлэхэд “Тодорхой байдал” маш чухал юм.

⁷⁵ <http://www.worldwide-tax.com/#partthree>

⁷⁶ “Discover Mongolia – 2011” чуулга уулзалтын хэлэлцүүлгээс судлаачийн хийсэн дүгнэлт

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ШАЛГАРАХ МАГАДЛАЛ БҮХИЙ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ КОМПАНИУД

1. ОХУ, Япон, БНСУ-ын хамтарсан консорциум

1.1. ОХУ-ын компаниуд

- “РЖД” (Оросын төмөр зам/ОТЗ)

Оросын төрийн өмчит компани. Улсдаа толгойлох, монополь компани. ОХУ-ын ДНБ-ний 2.5%-ийг бүрдүүлдэг. Эзэмшлийн төмөр замын урт нь 85,500 км.

- “СУЭК” (Сибирийн эрчим хүч, нүүрсний компани)⁷⁷

ОТЗ-тай хамтарч тендерт оролцож байгаа. 2001 онд байгуулагдсан, нээлттэй хувьцаат нийгэмлэг. Киприйн аралд бүртгэлтэй. Нийт хувьцааны 99.84%-ийг Киприйн “Donalink Ltd” компани эзэмшдэг, үлдсэн 0.16% нь “Красноярскийн уурхай” компаний нэр дээр байдаг. Орос орны өнцөг булан бүрт нүүрс олборлож, үзүүлэлтээрээ 1-р байрт итгэлтэй орсон. Нийт 46,000 ажилтантай. Ойрын 10 жилд нүүрс олборлолт төдийгүй боловсруулах үйлдвэрлэлд дэлхийд тэргүүлэх байрыг эзлэх бизнесийн уриатай.

Буриад, Кемеров муж, Красноярск, Приморын хязгаар, Хакасид олон тооны уурхайтай. Европын улсууд, Япон руу нүүрс экспортолдог. Сонирхол татах олон төсөл хэрэгжүүлж байгаа. Юуны өмнө Ванино боомтод (Мучке өртөө) жилдээ 12 сая тн нүүрс экспортлох хүчин чадалтай терминал ашиглалтанд оруулна. Мөн Хабаровск мужид нүүрс боловсруулах (угаах) үйлдвэр байгуулахаар төлөвлөжээ. 2007 онд “Газпром” компанитай нэгдэж нүүрс, нефть, хийн аварга консорциум байгуулах төлөвлөгөөтэй байсан боловч ОХУ-ын Монополийн эсрэг алба ба Эрчим хүчний нэгдсэн сүлжээний эсэргүүцэлтэй тулгарч хэрэгжээгүй.

1.2. Японы компаниуд

- “Itochu” (Иточу)

Тус компани үйл ажиллагаагаа 1858 онд кимоногийн худалдаагаар эхэлж байв. Компаний цэвэр ашиг 2007 онд 218.6 тэрбум йен хүрч байв. Эрчим хүч, эрдэс баялаг, металл, даавуу, санхүү, ой мод, содон бүтээгдэхүүн, даатгал, үл хөдлөх хөрөнгө, машин техникийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

- “Marubeni” (Марубени)

1858 онд байгуулагдаж, зотон даавууны худалдаагаар үйл ажиллагаа нь эхэлсэн. Үйл ажиллагаа нь жилээс жилд өргөжсөөр “Тоцу”, “Нанё Буссан” компаниудыг нэгтгэсэн.

- “Sumitomo” (Сумитомо)

1615 онд байгуулагдаж, номын дэлгүүрийн худалдаагаар үйл ажиллагаа нь эхэлсэн. Хүнд үйлдвэр, банк санхүү, цемент, хөнгөн үйлдвэр, химийн бүтээгдэхүүн, уул уурхай, автомашин, компьютерийн салбарт үйл ажиллагаа явуулдаг, дэлхийд хэрсэн сүлжээтэй.

- “Sojitz” (Сожиц)

2004 онд “Нисшо Ивай”, “Ничимэн” корпораци нэгдэж байгуулсан. Олон салбарт

⁷⁷ Монголын Уул уурхайн Ассоциацийн вэбсайт, <http://mmpa.mn>

Судалгааны эмхтгэл, XI боть

үйл ажиллагаа явуулдагаас уул уурхай томд нь тооцогдоно. 2010 онд 95 сая ам. долларын ашигтай ажиллажээ.

1.3. БНСУ-ын компаниуд

- “Koreas” (Корес) Групп.

2. ”Mitsui & Co” (Мицуй, Япон)⁷⁸

1947 онд байгуулагдсан. 65 улсад 151 салбартай. Хөрөнгө оруулалтаар дэлхийд тэргүүлдэг. Японы голлох компаниудын нэг. Үйл ажиллагаа: ган төмрийн үйлдвэрлэл, химийн үйлдвэрлэл, эрчим хүч, жижиглэн худалдаа, хоол хүнс, автомашин, харилцаа холбоо, дэд бүтэц, тээвэр Тавантолгойн тендерт Хятадын “Шинхуа”-тай нэгдэл болон оролцож буй.⁷⁹

3. “Xstrata Coal” (Экстрата Коол, Австраль-Швейцарь)

Консорциум. “Нүүрсний акул”. Коксжих нүүрсний 5 дахь том үйлдвэрлэгч. Өмнөд Африкийн томоохон нүүрс олборлогч. Австралийн нүүрсний экспортын манлайлагч. Дэлхийн 30 гаруй улсад үйл ажиллагаа явуулдаг.

4. “Vale” (Валэ, Бразил)

Үндэстэн дамнасан компани. “Нүүрсний шуналтан”. 1942 онд байгуулагдсан. Уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлийн хүчин чадлаараа дэлхийд хоёрт жагсдаг. Төмрийн хүдэр, зэс, төмрийн хайлш, нүүрс хүчлийн кали, хөнгөн цагаан салбарт амжилттай ажиллаж байгаа. Бразилийн нийт экспортын 11.9% Валэд ноогддог. 2010 онд 5.5 тэрбум долларын цэвэр ашигтай ажилласан. 5 тивийн 38 оронд салбар нэгжтэй. Мозамбикт жилдээ 14 сая тн металлургийн болон эрчмийн нүүрс олборлох, 70 жилийн нөөцтэй уурхайтай. Австралид 2.7 тэрбум тн нүүрсний нөөцтэй ордыг эзэмшдэг.

5. “Arcelor Mittal” (Арсэлор Митал, Люксембург)

Дэлхийн “гангийн үйлдвэрлэлийн магнат” тодотголтой энэ компани 1989 онд байгуулагдсан. 2010 онд 90.6 сая тн боловсруулаагүй гангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж (дэлхийн гангийн бүтээгдэхүүний 8%-ийг эзэлнэ), 78 тэрбум долларын ашигтай ажилласан. 60 оронд өөрийн төвтэй. 4 тивийн 20 орны аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг.

6. Пийбоди Энержи /Peabody energy/ компанийн танилцуулга

Харьяалал: АНУ,

Хаяг: Peabody Energy, 701 Market street, St.Louis, Missouri 63101. www.peabodyEnergy.com

Товч түүх: Тус компани нь 125 жилийн турш уул уурхайн үйлдвэрлэл явуулж байгаа хувийн компани. Гол үйлдвэрлэл нь нүүрс үйлдвэрлэл - ил уурхай. Дэлхий даяар нийт есөн тэрбум тонн нүүрсний батлагдсан нөөц олборлох эрхтэй. Дэлхийн эрчим хүчний үйлдвэрлэлийн хоёр хувь, АНУ-ын арван хувийг дангаараа бүрдүүлдэг. 2011 оны эхний улирлын байдлаар нийт 61.2 сая тонн нүүрс олборлож, тонн тутмынхаа ашгийг 43 хувиар нэмэгдүүлжээ.

Гол үйлдвэрлэл нь Вайоминг муж улсын Паудэр голын хөндийд байрлах Хойд Антелопын

⁷⁸ Б.Алисиа, Mongolian Mining Journal

⁷⁹ Монголын Уул уурхайн Ассоциацийн вэбсайт, <http://mmpa.mn>

Рошеллийн нүүрсний уурхай. Хойд Антелопын Рошеллийн уурхай 100-аас дээш сая тонн нүүрс үйлдвэрлэх хүчин чадалтай, 1200 ажлын байртай. Цагт 11.000 тн нүүрсийг галт тэрэгний цуваанд ачаалдаг. Уурхайгаас өдөрт 28 галт тэрэгний цувааг ачиж гаргах хүчин чадалтай. Энэ нь жилд 10 000 галт тэрэгний цувааг ачих боломжтой гэсэн үг.

Уурхайн технологи: Хамгийн сүүлийн үеийн технологи, тоног төхөөрөмжийг уурхайд хэрэглэдэг. Модулын уурхайн систем гэж нэрлэгдсэн нэг систем нь:

- Ачааны машины маршрутыг удирдан хянадаг. Энэхүү хяналтын үр дүнд үйлчлүүлэгч, хэрэглэгчдэд шаардлагатай байгаа үзүүлэлт бүхий нүүрсийг холих боломжтой
- Машины операторууд, жолооч болон диспетчерүүд уг системийг ашиглан хөдөлмөрийн бүтээмжээ цаг тухайд нь үнэлэх боломжтой.
- Дэлхий нийтийн байрлалын системийг /GPS/ ашигласнаар талбай дээр ажиллаж буй нийт ачааны машины хөдлөх бүрэлдэхүүний байршлыг тогтоож, экскаватороос ачааны машин, ачааны машинаас галт тэргэнд очих циклийг хянах боломжтой.
- Диспетчерийн баг болон машины оператор хоорондоо шууд харилцаж, нүүрсний холимгийг тохируулах, нүүрсний үзүүлэлт, чанарыг дээшлүүлэх бололцоотой.

Түүнчлэн хамгийн сүүлийн үеийн технологийг ашигладаг драглайн /экскаватор/, конвейерийн дамжуулах бүс болон нүүрс холих системд хөрөнгө оруулалт хийсэн нь хөдөлмөрийн бүтээмжийг эрс нэмэгдүүлж, зардал хэмнэж, нүүрсний чанарыг сайжруулсан гэж үзэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа: Пийбодид ажиллаж буй хүн бүрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар доорхи зарчим үйлчилдэг.

- Хамгийн үнэ цэнтэй хөрөнгө болох ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд бол тус компанийн бүхий л үйл ажиллагааг хамарсан үнэ цэнэ гэж тооцогддог.
- Бүхий л төрлийн осол аваар түүний дотор гэмтэл, мэргэжлийн өвчин, өмч хөрөнгөд учрах хохирол болон осол аваар үүсгэх байдлыг бүгдийг нь урьдчилан сэргийлж арилгаж болно.
- Ажилчны аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар удирдлага менежмент нь ерөнхий хариуцлага хүлээнэ.
- Ажилчин бүр өөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хариуцахаас гадна хамтран ажиллагсдынхаа аюулгүй байдлын төлөө санаа тавьж ажиллана.
- Ажилчин бүр өөрийн эрхэлсэн ажлыг аюулгүй байдлаар явуулахын тулд зохих мэдлэг, ур чадвар, эрх мэдэлтэй байх ёстой.
- Бүх ажилчин тогтоосон хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журмыг ягштал биелүүлэх ёстой.
- Аюулгүй байдлын талаарх нэн шаардлагатай мэдээлэл, харилцааг ил тодоор, үнэнч шударга, үр бүтээлтэйгээр явуулж байх ёстой.
- Аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тавьж буй бүхий л хүчин чармайлтыг байнга тууштай хэрэгжүүлж байх ёстой бөгөөд тогтмол эргэж харж, сайжруулж байх ёстой.
- Пийбодигийн ажилчин ажлаа явуулж байгаа бүхий л орчинг ажлын байр гэж тооцно.

Энэхүү зарчмыг компанийн удирдлагаас авахуулаад уурхайчин хүртэл хүн бүр даган мөрддөг байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төвлөрсөн баг баг ажилладаг. Уурхай бүр дээр бас ийм багтай. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг. Осол аваар гаргахгүйн төлөө харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагааны ётандарт журмыг сайжруулах, осол аваарын үндэс суурь болсон шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийхэд анхаарч ажилладаг. Сүүлийн 7 жилийн хугацаанд Пийбодигийн уурхайнууд нь АНУ-ын Хөдөлмөрийн яамнаас олгодог “Аюулгүй байдлын харуул” хэмээх өндөр шагналыг хүртсэн байна.

Байгаль орчныг хамгаалах чиглэлд:

Судалгааны эмхтгэл, XI боть

Уурхайн үйл ажиллагаа явуулсан газрыг өмнөх байдалтай ижил эсвэл түүнээс илүү байдалтай болгох чиглэлээр нөхөн сэргээлтийн ажлыг хийдэг. Үүнд:

- Бэлчээрийн газар
- Зэрлэг амьтад оршин амьдрах орчин
- Ой
- Намаг
- Соёл амралтын газрууд бий болгох
- Соёлын өвийг хадгалах чиглэлээр нөхөн сэргээлт хийдэг.

Нөхөн сэргээлт хийхдээ анхаардаг зүйлс:

- Нутгийн иргэдтэй хамтран ажилладаг
- Байгаль орчны чиглэлийн эрдэмтэн, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажилладаг. Тодорхой жишээ: 2010 онд Булган аймгийн Эрээний уурхайг ашигласны дараа Монгол улсын Засгийн газар, ХААИС, Монголын Бэлчээрийн үр, ургамлыг тариалагчдын холбоотой хамтран нөхөн сэргээлт хийсэн нь Монгол улсад анх удаа нүүрсний уурхайн газарт иж бүрнээр нь нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулсан тохиолдол юм.

7. Уул уурхайн Макмахон /Macmahon/ компанийн танилцуулга

Харьяалал: Австрали улс

Хаяг: Macmahon Holding Limited and Macmahon Contractors Pty Ltd. PO Box 198, Cannington, WA, 6987 Australia.

Гол үйлдвэрлэл нь: ил далд уурхай, уул уурхайн тоног төхөөрөмж нийлүүлэлт, уул уурхайн компанийн менежментийн удирдлага, дэд бүтцийн /зам, төмөр болон усан зам, усан сан/ барилга байгууламж.

Товч түүх: Тус компани нь Австралийн барилга үйлдвэрлэл болон Австрали, Шинэ Зеланд, Зүүн, Өмнөд Ази болон Африкийн томоохон төслүүд дээр ажилладаг уул уурхайн гэрээ хэлцлийн тэргүүлэгч компани.

50 гаруй жилийн ажлын туршлагатай.

Гол удирдлага нь Пэртэд /Perth/ байрлах бөгөөд Сидней, Брисбан, Дарвин, Аделаид, Куалалумпур, Хонг Конг, Лагост салбарууд нь бий. Нийт ажиллагсдын тоо 3000 гаруй.

Тус компанийн бусдаас ялгагдах онцлог нь бүх төрлийн тээвэр, далайн хөлөг онгоц, ус болон дэд бүтцийн үйлчилгээний нөөцөөрөө илүү давамгайл бөгөөд энэ чиглэлээр Засгийн газрын болон хувийн секторын байгууллагуудтай хамтран ажилладаг.

Мөн ажиллагсдынхаа эрүүл мэнд болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангахад ихээхэн туршлага хуримтлуулсан.

Уул уурхайн чиглэлээр ил болон далд уурхайн үйлдвэрлэлээс авахуулаад дэлхийн томоохон хэд хэдэн уурхайн компанийг менежментийн удирдлагаар хангаж ажилладаг. Макмахон нь уул уурхайн төрөл бүрийн тоног төхөөрөмж нийлүүлэх, үйлчлүүлэгчээ дээдэлсэн гэрээ контракт хийх талаар маш их мэргэжсэн компани.

Компанийн алсын хараа ба үнэт зүйлс нь:

Тус компанийн үйл ажиллагааны алсын хараа болон үнэт зүйлс тэдний ажиллагсад болон хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчдийнхээ эрх ашгийг дээдлэхэд оршдог байна.

Алсын хараа нь:

- Ажиллагсдынхаа төлөө ажиллах
- Хэрэглэгчдийнхээ төлөө зарцуулах
- Хувьцаа эзэмшигчдийнхээ төлөө хөрөнгө оруулах гэсэн уриаг гол болгодог.

Үнэт зүйлс нь:

Нийт ажиллагсдынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дээдлэх. Үүнд:

- Аюулгүй байдал- Өөрийгөө, багынхныгаа, бусдыг халамжлах
- Багаар ажиллах-Ухаалга ажиллах, мэрийж ажиллах, хамтдаа ажиллах
- Хөгжил цэцэглэлт буюу амжилт-Бүх харилцагч, хувьцаа эзэмшигч, ажиллагсад, үйлчлүүлэгчдийнхээ төлөө үнэт зүйлсийг бүтээх
- Шударга байдал-Хэлснээ биелүүлэхийн төлөө чармайх
- Байгаль орчин: 3R зарчим буюу бууруулах /багасгах/, дахин ашиглах, сэргээн засварлах /шинэчлэн босгох/

Компанийн зарчим нь:

- Алсын хараа ба үнэт зүйлс /**Vision and Values**/
- Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Байгаль орчин ба Чанар /HSEQ-Health, Safety, Environment, Quality/
- Эрсдлийн менежмент /Risk Management/
- Ажлын байран дахь Workplace Relations

Монголын нүүрсний төсөлд онцгой эрхтэй гэрээ байгуулагчийн мэдээлэл

Макмахон /Masmahon Holdings Limited/ ХХК нь Германы Би Би Эм Оперта групптэй хамтран Монгол улсын нүүрсний уурхай Таван толгойд оператор компаниар ажиллах болсноо зарлаж байна.

Таван толгойн нүүрсний төслийн эзэмшигч төрийн эзэмшлийн Эрдэнэс Таван толгой JSC нь Германы Би Би Эм Оперта групптэй хамтрагч Макмахон /Masmahon Holdings Limited/ ХХК –ийг онцгой гэрээ байгуулагч гэж зарласан.

Энэхүү гэрээ нь Улаанбаатараас өмнө зүгт 540 орчим км алс хол, Монголын Өмнөговь аймагт орших Таван толгойн Зүүн Цанхид их хэмжээний ил уурхайн операторын үйл ажиллагааг хамрах болно. Урьдчилан төлөвлөснөөр, дэд бүтэц тавигдсан /шийдэгдсэн/ тохиолдолд жил бүр олборлох нүүрс 15 сая тонн /15 million tones/ нүүрсээр нэмэгдэх төлөв байгаа.

Масмахон ХХК-ийн Гүйцэтгэх албаны дарга Ник Бовен “Тус компанийн ололт амжилтууд нь Монголын нүүрсний салбарын аюулгүй ажиллагааг сайжруулна” гэж хэлэв. Тэрбээр цааш нь “Таван толгойн төслийн хөгжил дэвшил нь одоогоор Масмахоны бат суурьд нөлөөлж байгаа бөгөөд гол хүчин чармайлт нь дэлхийн хамгийн том хөгжиж буй уул уурхайн бүсийн урт хугацааны бизнесийн суурийг тавихад оршино” гэжээ. Масмахон болон Би Би Эм Оперта хамтарсан групп нь Эрдэнэс Таван толгой компанитай ирэх сард гэрээний зүйл заалтыг дуусгахын тулд хамтран ажиллах болно.

* * *

8. Шинхуа Энержи /China Shenhua Energy Company Limited/ компанийн танилцуулга

Харьяалал: БНХАУ

Байрлал: БНХАУ, Бээжин хот

Гол үйлдвэрлэл: нь нүүрс олборлолт, тээвэрлэлт, цахилгаан эрчим хүчний нүүрс нийлүүлэлт.

Товч түүх: “Шинхуа групп” корпораци нь 2004 оны 8-р сард Хятадын Шинхуа Энержи ХХК /China Shenhua Energy Company Limited/-ийг тусгайлан үүсгэн байгуулжээ. /зарим хэвлэлийн мэдээнд 1995 онд гэж бичжээ/

Шинхуа энержи нь Хятадын төрийн өмчит компани.

Н болон А хувьцаа нь 2005 оны 7-р сар, 2007 оны 10-р сард тус тусдаа Хонг-Конг, Шанхайн хөрөнгийн бирж дээр бүртгүүлсэн. “Шинхуа Энержи” нь нийт 224.8 сая тонн нүүрсний нөөц эзэмшиж, Хятадын нүүрсний экспортын 38 хувийг дангаараа хангадаг компани. Нүүрс олборлолтоороо улсдаа тэргүүлдэг, харин дэлхийд гуравдугаарт ордог. Хятадын Шинхуа Энержи нь нүүрс үйлдвэрлэлд суурилсан дэлхийн томоохон эрчим хүчний компани. Тус компанийн гол бизнес нь нүүрс үйлдвэрлэлт болон борлуулалт, төмөр болон усан замын нүүрс тээвэрлэлт. Тус компанийн нүүрсний бизнес нь Хятадын нүүрсний үйлдвэрлэлийн хамгийн аюулгүй болон өндөр үр ашигтай өргөн цар хүрээтэй үйлдвэрлэлээр шалгарчээ.

2009 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Шинхуа Энержи нь Хятад улсын уул уурхайн үйлдвэрлэлийн стандартын дагуу урьдчилан тооцоолсоноор 11.306 тэрбум тонн олон удаа ашиглаж болохуйц нүүрсний нөөцийг эзэмших, олон улсын JORC байгууллагын урьдчилан тооцоолсноор 6.927 тэрбум /billion tons/ тонны нүүрснийг борлуулах чадвартай гэж тогтоогдсон.

2009 онд Шинхуа Энержи 210.3 сая тонн нүүрс үйлдвэрлэсэн нь өмнөх жилийнхээс 13.2%-иар, 254.3 сая тонн нүүрс борлуулсан нь өмнөх жилийнхээс 9.3%-иар тус тус өссөн байна. 2009 онд түүхий нүүрсний хорогдол /тонн тутамд/ нь 0.017 байж.

Шинхуа нь усан болон төмөр замын өргөн хүрээний тээврийн сүлжээтэй бөгөөд үүнд Хятадын Өрнөөс Дорно руу нүүрс тээвэрлэдэг /уртаараа Хятадаа 2 дахь/ Shenshuo-Shuohuang төмөр замын оператор компани, Хуанхуа усан онгоцны боомт, Шинхуа, Тэньжиний нүүрсний боомт зэрэг 5 том байгууламжийг ажиллуулдаг. Эдгээр нь үйлдвэрлэлийн үр ашиг асар их өндөр бөгөөд тээвэрлэлтийн зардлыг маш ихээр хэмнэдэг байна.

2009 онд тус компанийн хувийн эзэмшлийн төмөр замын нүүрс тээвэрлэлтийн эргэлт нь 138.2 тэрбум тонн-км, усан замын боомтоор нүүрс тээвэрлэлт нь 159.2 сая тн-д хүрчээ. Шинхуа Энержи компани тухайн улсын эрчим хүчний сүлжээнд ороогүй 413 мегаваттын хүчин чадалтай 13 дулааны цахилгаан станцын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан туршлагатай.

2009 онд Шинхуа энержи 105.09 тэрбум киловатт цагийн үйлдвэрлэл явуулсан нь өмнөх жилээс 7.5 хувиар өсчээ. 2009 онд Шинхуагийн бүтэн жилийн орлого нь 121.372 тэрбум юаньд хүрсэн байна. Бизнесийн байгууллагын стандартын дагуу компанийн нийт үндсэн хөрөнгө 310.514 тэрбум юань болсон бөгөөд үүнээс хувьцаа эзэмшигчдийнх нь 30.276 тэрбум, нэгж хувьцааны ашиг орлого нь 1.522 юань байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд:

	Unit(RMB)	2007	2008	2009
--	-----------	------	------	------

• Орлого /Revenues /	Сая юань million yuan	82,107	107,133	121,312
• Үйл ажиллагааны ашиг/ Operating profit	million yuan	32,497	39,675	47,108
• Жилийн ашиг /Profit for the year	million yuan	24,037	29,899	36,186
• Компаний энгийн хувьцаа эзэмшигчдийн хамааруулж болох ашиг / Profit attributable to equity shareholders of the Company	million yuan	20,581	26,641	31,706
• Нэгж хувьцаанд ноогдох ашиг/ Earning per share	Yuan	1.110	1.339	1.594
• Нийт актив /Total assets	million yuan	238,527	275,540	311,677
• Нийт өр/Total liabilities	million yuan	88,723	103,797	114,259
• Нийт тэнцэл / Total equity	million yuan	149,804	171,743	197,418
• Компанийн энгийн хувьцаанд хамааруулж болох хөрөнгө/ Of which: equity attributable to equity shareholders of the Company	million yuan	129,788	147,432	170,661

* * *

Нүүрс үйлдвэрлэх технологи:

2009 онд тус компани Шинхуа Энержи групптэй хамтран Шинхуа группын нүүрс үйлдвэрлэлийн технологи болон тоног төхөөрөмжийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд:

- Шинхуа группийн уул уурхайн тоног төхөөрөмжид нарийвчилсан шалгалт хийх нөхцөл
- Шинхуа группын тоног төхөөрөмжийн техникийн тайлан болон уул уурхайн тоног төхөөрөмжийн хаягдлыг зайлуулах стандарт
- Тоног төхөөрөмжийн хүчин чадлыг дээд зэргээр ашиглах зорилт
- Нүүрс үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт
- Уул уурхайн тоног төхөөрөмжийн стандарт болон нүүрс үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зэрэг асуудлууд багтжээ.

ОРДЫН АШИГЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААРХИ ТӨРИЙН БОЛОН ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГУУД, ЭРДЭМТЭН СУДЛААЧДЫН САНАЛ ШҮҮМЖ

Тавантолгойн ордыг ашиглах боломжит хувилбаруудын талаар олон нийтийн зүгээс гарч буй санал шүүмжлэлд контент анализ хийхдээ өдөр тутмын хэвлэл болох “Зууны мэдээ”, “Өнөөдөр”, “Ардын эрх”, “Өдрийн сонин”, “Үндэсний шуудан” зэрэг сонины 2009-2011 оны 10 сарын 4-ний өдрийг хүртлэх дугаарууд болон өдөр тутмын мэдээллийн вэб сайтуудаар гарсан нийтлэлүүд болон 2011 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Иргэний танхимд зохион байгуулагдсан “Тавантолгойн нүүрсний ордыг хэрхэн үр ашигтай ашиглах вэ?” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санал, шүүмжлэл зэргийг судаллаа.

Судалгааг гүйцэтгэх явцад Тавантолгойн ордыг ашиглах боломжит хувилбаруудын талаар олон нийтээс гарсан саналыг 3 үндсэн чиглэлээр гаргасан болно.

1. Ордын ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар олон нийтээс гарч буй санал

Олон нийтээс гарч буй саналын хувьд дараахь хэд хэдэн асуудлыг хөндсөн байна. Үүнд:

1/ Тавантолгой ордноос зөвхөн нүүрс олборлох бус харин дэд бүтэц, эрх зүйн орчин болон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортын орлого түүнээс үүдэн гарах татварын бодлогыг төрийн зүгээс тодорхой болгох шаардлагатай байна.

2/ Нүүрсний ханшид нөлөөлөх хамгийн гол хүчин зүйл болох тээврийн маршрутын талаар хэд хэдэн хувилбарыг гаргасан байна. Тавантолгойн нүүрсийг БНХАУ, ОХУ гэсэн хөрш орнуудаар дамжуулан дэлхийн зах зээлд борлуулах бөгөөд харин яг ямар маршрутаар тээвэрлэх нь манай улсын хувьд ашигтай болох талаар дараахь хувилбарыг гаргажээ.

Нийтлэлийн нэр, огноо	Санал болгож буй хувилбарууд
Сэтгүүлч О.Хосцэцэг “Боломж, гэхдээ алтан давуу тал...” Өдрийн сонин 2009.11.23-ны өдрийн 282 дугаарын 5-р нүүрт	Манай улсын импортын гол гарц болох Замын-Үүд боомтын хүчин чадал өнөөдөр Таван толгойн коксжих нүүрсийг нэмж нэвтрүүлэх боломж олгохгүй юм. Тиймээс Замын Үүд боомтын хүчин чадлыг сайжруулах, Гашуун сухайт, Нарийнсухайтын чиглэлийн төмөр зам байгуулах, ингэснээр Монгол Улс нүүрс тээвэрлэх хойшоо, урагш чиглэсэн олон гарцтай болох боломжтой юм.
Сэтгүүлч А.Алтантуяа “Яагаад хоёр гурван салаа замтай байж болохгүй гэж?” Ардын эрх сонины 2009.12.01-ний өдрийн 233 дугаарын 1, 3-р нүүрт	Гашуун сухайт руу төмөр зам тавихад 240 км, богино бөгөөд тээвэрлэлтийн зардал бага байх магадлалтай. Харин Даланзадгад, Сайншандын чиглэлээр 554 км зам тавин өнөөгийн төмөр замын төв терминальтай холбогдоод цаашилбал Хятадаас гадна ОХУ гэх мэт бусад гарц руу холбогдох боломжтой.
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Н.Алтанхуяг “Таван толгойн орд газрыг яаралтай эдийн засгийн эргэлтэнд оруулах шаардлагатай” Ардын эрх сонины 2009.12.02-ны өдрийн 234 дугаарын 2-р нүүрт	Монгол Улсын Засгийн газар Тавантолгойн орд газраа аль болох хугацаа алдалгүйгээр эдийн засгийн эргэлтэнд оруулж, нүүрсний экспортыг нэмэгдүүлж, хатуу хучлагатай зам тавих ажлыг эхлүүлэх шаардлагатай байгаа юм. Тавантолгойн орд газраас 250 км-ын зайд орших Гашуунсухайт боомтын хувьд хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай.
УИХ-ын гишүүн ЗТБХБ-ийн сайд Х.Баттулга “Өнгөц харахад алсуур, өртөг өндөр мэт харагдах боловч ирээдүйн өгөөжийг нь харах учиртай” Ардын эрх сонины 2009.12.07-ны өдрийн 237 дугаарын 3, 4-р нүүрт	Орхон аймагт Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Дархан-Уул аймгийн төмөрлөгийн үйлдвэртэйгээ уялдуулан хөгжүүлэхийн тулд одоогийн төмөр замтайгаа огтлолцуулан Тавантолгойгоос Сайншанд хүртлэх 500 орчим км төмөр замыг шинээр барих, Цаашилбал энэ зам Чойбалсан хотын өргөн төмөр замаар дамжин ОХУ-ын транс Сибирийн төмөр замын сүлжээтэй холбогдон Европын зах зээлрүү хагас боловсруулсан бүтээгдэхүүн гаргах бас нэгэн гарц байгаа
УИХ-ын гишүүн Х.Бадамсүрэн “Бодлого тодорхой биш учраас бид ажлынхаа дэс дарааг алдчихаж” Өнөөдөр сонины 2009.12.11-ний өдрийн 285 дугаарын А2-р нүүрт	Оюутолгой, Тавантолгойг холбох төмөр замыг гол төмөр замтайгаа холбох хэрэгтэй. Уул уурхайн бүтээгдэхүүн урд хөршид нийлүүлэхийн зэрэгцээ Таньжин боомт хүрч байж л дэлхийн зах зээлд гарна. Тийм учраас шууд урагш чиглэсэн төмөр замаа ч барих хэрэгтэй, төв төмөр замтайгаа ч холбох нь зүйтэй. Хоёулаа л баригдах ёстой.

Сэтгүүлч Н.Хулан “Монголын хоёр дахь саалийн үнээ Сайншандын цогцолбор” Монголын мэдээ сонины 2009.12.14-ний өдрийн 245 дугаарын 5-р нүүрт	Ухаахудагаас Сайншанд руу төмөр зам тавьж, Монгол Улсын төмөр замын төв магистралтай холбовол Тавантолгойн нүүрс олон улсад гарц нээгдэнэ. Цаашлаад Сайншандыг хүн аж үйлдвэрийн цогцолбор болгоод, нүүрсээ боловсруулаад гаргавал нэмүү өртөг нь манайд үлдэнэ. Манай улсын эдийн засаг ч тэр хэмжээгээр сэргэнэ гэсэн үг юм.
“Эрс шинэчлэл” хөдөлгөөний тэргүүн С.Ганбаатар: “Оросын олигархиас салах хэрэгтэй.” Зууны мэдээ сонины 2009.12.14-ний өдрийн 291 дугаарын 5-р нүүрт	Нүүрсээ борлуулъя гэж байгаа бол хамгийн ойрхон, хамгийн том зах зээл болох Хятад руу гаргах хэрэгтэй. Үүний тулд цаанаас угтуулан барьсан Тяньжин боомт руу аль болох ойрхон төмөр зам барих ёстой.
Сэтгүүлч Д.Болдхуяг “Тавантолгой, Монголчуудын хожил” Зууны мэдээ сонины 2009.12.15-ны өдрийн 292 дугаарын 3-р нүүрт	“Ухаахудаг”-аас Тяньжин хүрэх тээврийн өртөг ч өргөн царигитай тойруу маршрутаас дор хаяж гурав дахин хямд байх тооцоо гарчээ. Гашуунсухайт-Бугатын чиглэлийн нарийн төмөр зам нь зөвхөн Хятад биш Япон, Солонгос, Энэтхэг гэсэн гурван том худалдан авагчид Тяньжин боомтоор дамжин хүргэх дөт зам юм. Находкагаар дамжихаас гурав дахин, Ваниногоор дайруулахаас бараг дөрөв дахин богино юм. Гашуунсухайт-Бугатын чиглэлийн нарийн төмөр зам нь зөвхөн Хятад биш Япон, Солонгос, Энэтхэг гэсэн гурван том худалдан авагчид Тяньжин боомтоор дамжин хүргэх дөт зам юм. Находкагаар дамжихаас гурав дахин, Ваниногоор дайруулахаас бараг дөрөв дахин богино.
“Угтуулан тавих нөхцөлөө яасан бэ?” Ардын эрх сонины 2010.07.05-ны өдрийн №130 дугаарын 3, 5 –р нүүрт	Хэрвээ Оросын компанийг сонгохгүй бол Алс Дорнодын удам замаар Тавантолгойн нүүрсийг дотоодын тээврийнхээ тарифыг гурав дахин нугалсан өндөр үнээр зөөнө өө. Хятадын компани оператор болоогүй нөхцөлд тус улсын төмөр замын тээврийн маш их ачаалалтай графикт Тавантолгойн нүүрстэй вагон хэзээ ч нэвтэрч чадахгүй ээ. Далайн боомт ашиглах боломжийг ч Монголын нүүрсэнд тийм амархан олгохгүй ээ.
Д.Доржпагма “Төмөр зам хоёр хөршийн алин руу нь чиглэх вэ?” Өдрийн сонины 2009.11.25-ний өдрийн 284 дугаарын 2-р нүүрт	Таван толгойгоос Зүүн баян-Сайншандаас цааш Чойбалсан-Алс Дорнод хүртэл 1000-аад км үргэлжлэх төмөр зам барьж ОХУ-ын Трансибирийн төмөр замтай холбох нь эдийн засгийн хувьд илүү ач холбогдолтой гэж тооцоолжээ. Мөн Тавантолгойгоос Гашуун сухайт хүтэл 260 км төмөр зам барих учир өртөг зардал нь ОХУ-ын чиглэлд тавьсанаас хамаагүй бага, 300-500 сая ам.доллар шаардлагатай ажээ.

3/ Тавантолгойн нүүрсийг түүхийгээр нь экспортлох бус харин боловсруулан үнэ хүргэж, зах зээлд борлуулах, үүний тулд нүүрсийг боловсруулах чиглэлийн үйлдвэрийг байгуулах явдал юм. Тавантолгой коксжсон нүүрсний асар их нөөцтэй. Үүнийг ашиглаад ган үйлдвэрлэж, төмөртэй болж болно. Мөн нүүрсээ боловсруулаад экспортлоход нэмүү өртөг нь нэмэгдэж, тэр хэрээр манай улсын эдийн засаг сэргэх юм.

Тавантолгойн нүүрсийг боловсруулах талаар олон нийтийн зүгээс гаргасан саналыг нэгтгэн үзвэл:

- Боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон алхам гэж үзсэний үндсэн дээр Сайншандын хүнд үйлдвэрийн цогцолбор барих. Сайншандын цогцолбор нь олборлох салбарт түшиглэсэн манай явцуу эдийн засагт өөрчлөлт авчрах нь ойлгомжтой юм. Эдийн засгийн утгаар нь авч үзвэл, наад зах нь түүхий эдээс гурав дахин их ашиг, 400 мянга орчим ажлын байр бий болох ажээ.⁸⁰

⁸⁰ Г.Өлзийсайхан “Түүхий эдийн бааз болгох урд хөршийн сонирхол” Өнөөдөр сонины 2009 оны

- Сайншандад босгохоор төлөвлөсөн хүнд аж үйлдвэрийн цогцолбортой Тавантолгой, Оюутолгой, Нарийн сухайтыг холбочих нь өнөөдөртөө хамгийн зөв шийдвэр. Нүүрснээс коксыг нь ялгаж авбал, нэг ёсондоо өрмийг нь засчихвал тонн нь өнөөдөр 400 шахам долларт хүрч байна. Харин түүхий шороотой нь зөвөөл 60 ам доллар байна.⁸¹
- 30 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадал бүхий уурхай байгуулахаар төлөвлөж байна. 1200 ажлын байр тэнд гарна. 25 сая тонн нүүрс угааж баяжуулах үйлдвэр байгуулахад мэргэжилтэй 700 ажилчин хэрэгтэй. Мэдээж уурхайг дагаад хот байгуулалт түүнийг дагасан үйлдвэр, үйлчилгээний салбарууд бий болно. Мөн түүнчлэн Үйлдвэрээс гарах коксын хийгээр 40-50 мвт-ын цахилгаан станцыг хангах бололцоотой юм. Жилд 300 мянган тонн зэс үйлдвэрлэх зэс хайлуулах үйлдвэр, хоёр сая тонн ган, арматур, гөлмөн төмөр, төмөр замын рельс үйлдвэрлэх ган төмөрлөгийн үйлдвэр Тавантолгойн ордыг түшиглэж байгуулна. “Тавантолгой” төсөл 14 тэрбум долларын хөрөнгө оруулалтаар босож, ДНБ-ий хэмжээг 41 тэрбум долларт хүргэх тооцоотой, 76 мянган ажлын байр бий болгох Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор, энэ оноос барьж эхлэх 1770 км төмөр замын төсөл, говийн дэд бүтцийн төсөлтэй шууд холбоотой юм.

Аж үйлдвэрийн паркад кокс химийн үйлдвэр барьснаар бүтээгдэхүүний 72 хувь кокс, дөрвөн хувь нь хүхэр, зургаан хувь нь давирхай, 18 хувь нь коксын хий байх юм. Жилд 300 мянган тонн зэс үйлдвэрлэх зэс хайлуулах үйлдвэр, хоёр сая тонн ган, арматур, гөлмөн төмөр, төмөр замын рельс үйлдвэрлэх ган төмөрлөгийн үйлдвэр Тавантолгойн ордыг түшиглэж байгуулна.

4/ Стратегийн ордуудаас засгийн газар авбал зохих ашгийг авах гол арга зам бол аж ахуй нэгжийн орлогын албан татварыг ашигт малтмалын төрлөөр ялгавартай тогтоох, нөөц ашигласны /рояльтийн/ төлбөрийг өндөр тогтоох, зарим ордыг бүтээгдэхүүн хуваах, зарчмыг нь гэрээ түрээсээр /концессээр/ хөрөнгө оруулагчдад ашиглуулах.


2. Ордыг ашиглахад шаардагдах санхүүжилт /Гадаадын хөрөнгө оруулагчдын оруулах хөрөнгө, дотоодын хөрөнгө оруулагчдын олон улсын зах дээрээс хөрөнгө татах боломжууд/

Тавантолгойн ордыг ашиглахад шаардагдах санхүүжилтийн хувьд тухайн ордыг хэрхэн ашиглах, эдийн засгийн эргэлтэнд оруулахад хэдий хэмжээний санхүүжилт шаардлагатай байгааг төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын зүгээс нийт 14-20 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалтаар босч, ДНБ-ий хэмжээг 41 тэрбум долларт хүргэхээр дийлэнх нь дурьдсан байна. Харин үүнээс Тавантолгойн ордод эхний ээлжинд 3-5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэж үзсэн бөгөөд шаардагдах санхүүжилтийг Олон Улсын хөрөнгийн зах зээл дээр хувьцааг гаргах замаар босгох боломжтойг дурьджээ. Энэхүү санхүүжилтэнд шаардагдах хөрөнгийг гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг Олон улсын зах дээрээс хэрхэн татах, мөн ордыг ашиглахад шаардагдах санхүүжилтийг хэрхэн босгох хувилбаруудыг хүснэгтээр гаргалаа.

272 дугаарт

⁸¹ Д.Болдхуяг “Тавантолгой:Хятад руу нүүх үү, Монголд үлдэх үү” Зууны мэдээ сонины 2009 оны 279 дугаарт

<p>Олон улсын хөрөнгийн зах зээл дээр хувьцаа гаргах болон хувьцаа борлуулах</p>	<p>"Монгол 999" үндэсний нэгдэл Өдрийн сонины 2010.06.30-ны өдрийн 155 дугаарын 1, 6-р нүүрт: Тавантолгойн ордын хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээл дээр гаргахад 30 сарын дараа 15-20 орчим тэрбум ам.доллар олох бололцоо бий гэж тооцоолж байгаа юм. Мөн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 28 мянган аж ахуйн нэгж бүгдээрээ нэг сая төгрөг нийлүүлээд эхлэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх боломжтой. Таван толгойн ордыг хоёр хувааж гадаадын компанийг оператороор сонгон ажиллуулж, 10%-ийг ард иргэддээ үнэгүй тарааж, 10%-ийг үндэсний үйлдвэрлэгчдэдээ худалдах давуу эрхийг олгоно гэж байгаа. Харин Монгол 99 үндэсний нэгдлийнхэн төр буюу Засгийн газар 34, ард түмэн 33, Үндэсний үйлдвэрлэгч 33 хувийг эзэмшиж өөрсдөө олон улсын зах зээл дээрээс мөнгө босгох хувилбарыг санал болгож байна.</p>
	<p>МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Ганбаатар Өнөөдөр сонины 2010.07.05-ны өдрийн 155 дугаарын А4-р нүүрт: Замаа 250 тэрбум төгрөгөөр босгоно. Үүний урьдчилгаа 150 тэрбум төгрөгийг Монголын Засгийн газар эхний ээлжинд гаргаад Монголын автозамын 30 компанийг тендер шалгаруулалтаар шалгаруулаад арав, арван км-ээр замаа хуваарилан, мөнгөнийх нь 50-60 хувийг нь урьдчилж өгөөд үлдсэнийг нь дараа гүйцэтгэлээр тооцоход манай компаниуд 250 км замыг хоёр сарын дотор тавина. Хоёрдугаарт, 50-100 тоннын даацтай нүүрс зөөх машиныг дэлхийд алдартай ямар ч компаниуд зээлээр өгнө. Үүнийг зөвхөн зохион байгуулан, менежментийг нь хийгээд монголчуудаа ажиллуулахад коксжих үйлдвэр барихад шаардлагатай 2 тэрбум долларыг хоёр жилийн дотор олно.</p>
	<p>Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Р.Содхүү Үндэсний шуудан сонины 2010.7.06-ны өдрийн 159 дугаарын 5-р нүүрт: Үндэсний компаниудад эзэмшүүлэх 10, гадаадын хөрөнгө оруулагчдад борлуулах 30 хувийн хувьцааны мөнгө орж ирнэ. Тэр цагт бид хэнээс ч гуйхгүйгээр Тавантолгойн орд дээр олборлох, боловсруулах үйлдвэр барих хөрөнгийг босгоно.</p>
	<p>УИХ-ын гишүүн О.Чулуунбат Зууны мэдээ сонины 2010.07.06-ны өдрийн 161 дугаарын 3-р нүүрт: Тавантолгой дээр хөрөнгө босгох боломж их байна. Дэлхийн том том хөрөнгө оруулалтын банкууд төслийн зээл өгчихөөр сайхан баялаг байна. Хонг хонг, Лондонгийн бирж дээр баячууд хамтарсан фондууд байна. Тэнд мөнгө элбэг болохоор хөрөнгө хурдан босно. Заавал Монголын хөрөнгийн биржээр хувьцаа арилжаалаад байх шаардлага алга. Яваандаа монголчууд мөнгөтэй, хөрөнгөтэй бирж нь дэлхийн стандартын хэмжээнд хүрэхээр хувьцаа гаргаж мөнгө босгож болно.</p>
	<p>Доктор, профессор Г.Пүрэвбаатар Зууны мэдээ сонины 2010.07.07-ны өдрийн 162 дугаарын 5-р нүүрт: Гадаадын корпорациуд их нөөцтэй ордуудын хувьцааг хөрөнгийн биржүүд дээр борлуулж, босгосон мөнгөөрөө хөрөнгө оруулж байна. Бодит байдал дээр тэд хөрөнгө оруулагч биш, жижиг хувьцаа эзэмшигчдын хувьцааг багцалж зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, өөрсдийн захиргааны зардал, өндөр цалин хангамж өртөг зардлаа шингээж, ашгаас нь хүтэж, стратегийн ордыг өмчлөгч Монголын талд ногдох ашгийг багасгаж, хохироож байна.</p>
	<p>Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Өдрийн сонин 2010.07.14-ний өдрийн 165 дугаарын 1, 5-р нүүрт: Мөнгө босгох хоёр хэлбэр байдаг. Эхнийх нь банкаас зээл авах. Хүү төлөх хэрээр өртөг өндөр болдог. Төсвөөс хөрөнгө оруулж болох ч зах зээлийн зарчмаар асуудалд хандах ёстой гэж бид үзэж байгаа. Нөгөө хувилбар нь хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох. Бид бүх хувилбараар мөнгө босгохыг эрмэлзэж байна. Иргэн, аж ахуйн нэгжийнхээ оролцоог хангах зорилгоор дотоодын хөрөнгийн зах зээлд хувьцаа борлуулах боломжтой. Гадаадын үнэт цаасны зах зээлээс хөрөнгө татахыг үгүйсгэхгүй. Хэзээ, яаж үнэ хүргэх вэ гэдэг зарчмыг гол болгоно</p>



	<p>Х.Баттөгс Өдрийн сонин 2011.02.18-ний өдрийн 48 дугаарын 15-р нүүрт“Энержи ресурс” компани 13 сая тонн нүүрснээс нүд ирмэхийн зуур 700 сая ам.доллар босгожээ. Таван толгойн нэг хувиас 700 сая ам.доллар босгосон гэсэн үг юм. Энэ жишгээр тооцвол бүтэн Таван толгойгоос өлхөн 70 тэрбум ногоон босох боломжтой. Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугарын үзэж буйгаар хөрөнгө оруулагч банк хувьцааны үнийг тогтоох гэнэ. Яагаад бид өөрсдөө тогтоож болохгүй гэж. Гадныхан өөрсдөдөө ашигтай байх үнийг тогтоохыг оролдоно.</p> <p>Мэдээж анхны үнэ хувьцааны бодит ханшийг тогтоохгүй боловч дэлхийд тэргүүлэгч 16 банкны сонирхож байгаа хувьцаа хямд байх учиргүй. Өнөөдөр нэг хувьцаа нь мянган ам.доллар хол давсан олон компани бий. Хэдийгээр эхний ээлжинд Таван толгойн хувьцааны үнэ арван мянга биш боловч нэг мянган ам.доллараас доош байх учиргүй. Эхний ээлжинд IPO хийх нь хөрөнгө оруулалт, цаашдын үйл ажиллагааны зардлыг олох учраас өндөр байх нь ашигтай.</p> <p>Гэхдээ энэ нь хувьцааны ашиг арван мянгаас их байна гэсэн үг биш юм. Учир нь компани нэгж хувьцаанд ногдох ашгийг хувьцааны үнээр биш компанийн ашгаас нийт хувьцаанд ногдох ашгийг л хуваарилна. Өөрөөр хэлбэл арван мянган ногооны үнэтэй нэг хувьцаанд нэг доллар ч ногдож болно. Тиймээс Таван толгойн нэг хувьцааны үнэ зуун ногооноос хямд үнэлэгдэхгүй л болов уу.</p>
<p>Ордыг ашиглахад шаардагдах эхний санхүүжилтийг дотоодын хөрөнгө оруулагчдыг түшиглэн бий болгох</p>	<p>Монголын хүссэн бүх компанийг нэгтгэх нөхцөлөөр хувьцааных нь 33 хувийг эзэмшүүлбэл, нөөцийн хэмжээг тогтоох, техник-эдийн засгийн үндэслэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэнүүдээр хийлгэх, олон улсын зах зээлд гаргах хүртэл компанийн үйл ажиллагаанд гаргах зардлыг санхүүжүүлэх боломжтой болно. Энэ ажилд мэргэжилтэнүүдийн тооцоолсноор 20 гаруй тэрбум төгрөг шаардлагатай. Энэ мөнгийг монголын үндэсний компаниуд гаргах чадвартай байгаа гэж үзэж байна.</p>
	<p>Доктор Ч.Хурц Зууны мэдээ сонин 2010.07.06-ны өдрийн 161 дугаарын 11-р нүүрт: Тавантолгойн нүүрсний орд газрын тонн нүүрс газрын дор байхдаа 7-10 ам.доллар, гараад ирэхээр 18 ам.доллар, баяжуулж борлуулахаар 40 ам.доллар болно гэж ярьж байна. Газрын доор байгаа нүүрснийхээ үнийг тонн тутмаар үржүүлэхээр арван тэрбум ам.доллар болно. Энэ бидний оруулах хөрөнгө. Үйлдвэр барихдаа миний үндсэн хөрөнгө 10 тэрбумыг үйлдвэрийн фонд гэж тооц, тэгээд одоо хэдий хэр хөрөнгө хэрэгтэй вэ үүнийгээ ярьж гэж болно шүү дээ. Үнэлгээг тэгж хийдэг систем тогтоод байна.</p> <p>Тэр их нөөцтэй байна уу, бага нөөцтэй байна уу хамаагүй нөөц батлагдсан бол бүгдийг үнэлүүлж, улс орныхоо эдийн засгийн үнэлгээг бүртгэж, зөв тогтоох ёстой. Тавантолгойг эзэмшихэд саналаа өгсөн 15 компани байгаа шүү дээ. Зарим нь хоорондоо нийлчихсэн, зарим нь нийлээгүй байгаа. Тэр компаниудыг бид бүгдийг нь аваад, төр засгийн хэмжээнд маш сайн боловсруулсан удирдамжийн хэмжээнд саналаа тавих ёстой юм. Та нар тус бүрдээ нэг тэрбум долларын хөрөнгө оруулалт хий, энэ хөрөнгө оруулалтыг эзэмшиж, ажиллуулах консорциумыг хамтын хүчээр байгууль, хамтарсан консорциумын үйл ажиллагааг хамтарч удирдъя, ийм нөхцлийг оруулж ир гэх хэрэгтэй.</p>
	<p>Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавъяат эдийн засагч Д.Содном: Миний гол санал бол ер нь эхнээсээ тавиад байгаа гол санал бол Тавантолгой орд ашиглалтыг гадны хөрөнгө оруулагчдад биш Монголынхоо үндэсний хөрөнгө оруулагчдад хариуцуулах нь зүйтэй юм гэж үзэж байгаа юм. Яагаад монголчууд бид нар Тавантолгойнхоо ордыг өөрсдөө ашиглаж чадахгүй байна вэ. Хойд хэсэг дээр нь Энэржи ресурс хувийн компани олборлолт хийгээд тэр байтугай баяжуулах үйлдвэр байгуулаад явж болж байна. Ингэж болж байхад заавал гадныханд өгөх гээд байдаг энэ бол буруу гэж бодогдоод байна. Манайхан нүүрсний олборлолт баяжуулалтын хамгийн сайн техник технологийг олж ашиглах тийм чадвартай боловсон хүчинтэй болсон.</p> <p>Хэрвээ зарим онц чухал мэргэжилтэй хүн гадаадаас авах хэрэгтэй бол түүнийг уриад хөлслүүлж ажиллуулж болно. Төсөв санхүүжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бас олж болно. Одоо энэ олон банкууд чинь манайд ирээд танай энэ төсөл чинь ийм их үр ашигтай юм байна манайхаас зээл ав гээд өөрсдөө санал тавиад явж байна. Хэрэв бид зээл авч төслөө хэрэгжүүлвэл зээлээ төлсний дараа Монголын нутаг дээр үлдэнэ. Хэрэв гадаадын хөрөнгө оруулагчийг оруулах юм бол тэр бүх ашгийн чинь тодорхой хэсэг нь, тэгээд зээлийн хэлэлцээрийн бүх хугацаанд татварын дараах ашиг гадагшаа явна.</p>

Гурав. Тавантолгой ордыг ашиглах замаар Монгол Улсын иргэдэд хувь хүртээх боломж түүний хэлбэрүүд

Тавантолгойн ордыг ашиглах замаар Монгол Улсын иргэдэд хувь хүртээх боломж бий эсэх, энэхүү хувьцааг хүргэхдээ ямар арга замаар хүртээх тухай нарийвчилсан мэдээллийг олон нийтийн зүгээс гаргаагүй бөгөөд харин төрийн болон төрийн бус байгууллагаас Монгол Улсын нэг иргэнд хичнээн хувьцааг олгох ёстой, Тавантолгойн ордын хувьцааны хичнээн хувийг иргэдэд хүртээх талаар дараахь саналуудыг гаргасан байна.

Жич: Энэхүү контент анализыг хийхдээ 2009 - 2011 оны 10 сарын 04-ний өдрийг хүртлэх мэдээллийг ашигласан болно.

Үндэсний үйлдвэрлэгч, татвар төлөгч 2000 орчим компани, аж ахуйн нэгжийн санаачилсан байгуулсан “Монгол 999 үндэсний нэгдэл”-ийн Тавантолгой төслийн хүрээнд хийсэн тооцоо судалгаагаар

- Монгол хүн бүрт 25.9 мянган долларын үнэ цэнэ бүхий хувьцаа ноогдоно. Үүнээс жил бүр хамгийн багадаа 7 хувийн ногдол ашиг хүртэнэ гэж үзвэл иргэн болгон жил бүр 2.4 сая төгрөг авна.
- Тавантолгой төсөл дээр Засгийн газрын зүгээс баримталж байгаа бодлого нь оператор компанийг шалгаруулна, хөрөнгө оруулагчдын гэрээг байгуулна гэж байна. Оператор компани бол ажил хийх үүрэгтэй компани болохоос хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах шаардлагагүй. Уг нь энэ төсөл дээр үндэсний компаниуд нэгдэж хувь эзэмшиж чадвал үндэсний эрх ашигт хэрэгтэй болохоос цөөн хэдэн компаниудын эрх ашгийн асуудал биш юм.

Хамгийн сүүлд гэхэд Тавантолгойг ашиглах эрхтэй үндэсний компанийн хувьцааны 10 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан ард түмэндээ, 10 хувийг мөн биржээр монголын компаниудад худалдаад 51 хувийг нь төрийн мэдэлд авч үлдэнэ, 29 хувийг гадаадынханд олон улсын хөрөнгийн зах зээлээр дамжуулан худалдана гэсэн хувилбарыг оруулаад байна. Энэ хувилбарын сул тал нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжих үед гэсэн нэрийн дор Засгийн газартай тохиролцож 29 хувийг нь гадаад эзэд нь нэмж аваад хяналтын багцтай болно.

МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Ганбаатар:

- Нийт ард түмэнд Тавантолгойн хувьцааг 100 хувь өгөх ёстой. Монголын 2.7 сая ард түмэнд хүн нас барлаа, төр хувьцааг нь буцааж авна. Шинэ хүн төрөхөд тэр хувьцаанаасаа өгнө. Энэ маягаар хэдэн үеийнхэн маань Тавантолгойн эзэд болно. Харин парламент, Засгийн газар ард түмний эн өмчийн тодорхой хувь, ашгаар үйлдвэр, эмнэлэг, сургууль барихаар бол ард түмний төлөөлөл болсон парламентаар хэлэлцэж, шийддэг байх нь шударга ёсонд нийцнэ. Энэ бол үндсэндээ өмчийн эзэн болсон ард түмэн жинхэнэ хэлбэрээр эзэн нь байна гэсэн үг юм.

Тавантолгойн ордыг ашиглах замаар иргэдэд хувь хүртээх нь зөв, гэхдээ ямар байдлаар, хэдий хэмжээгээр хүртээх вэ гэдэг санал, хувилбарууд янз бүр байна. Нийтлэлүүдээс үзэхэд дээрх ерөнхий саналууд байгаа боловч зарим эрдэмтэдийн хувьд Тавантолгойн ордыг эзэмших хувьцааг ард нийтэд олгох нь буруу юм гэсэн санал ч гарсан байна. Тухайлбал:

- Доктор, профессор Г.Пүрэвбаатар: Тавантолгойн ордын хувьцааны 10 хувийг Монголын 2,8 сая иргэнд үнэ төлбөргүй эзэмшүүлж, байгалийн баялгийн орлогоосоо бүх ард түмэндээ хүртээнэ гэдэг бол эдийн засгийн бус, байж болохгүй арга юм. Ийм туршлага олон улсын практикт байдаггүй юм. Харин ногдол ашиг хуваах туршлага бий. Ингэхэд манай төр засгийн түшээд өөрсдөө иргэдийн хувьцааг цуглуулж

хөрөнгө зоорио арвижуулах далд санаагаар нийт ард түмэнд 10 хувийн хувьцаа эзэмшүүлэхийг санаачилсан ч байж мэдэх юм.

Тавантолгойн ордын хувьцааны 30 хувийг гадаад дотоодын хөрөнгийн бирж дээр борлуулж, мөнгө босгож, тэр мөнгөөр тус ордод хөрөнгө оруулна гэдэг бол стратегийн ордын хувьд байж болохгүй зүйл. Яагаад гэвэл, гадаад дотоодын хөрөнгийн бирж дээр борлуулсан 30 хувийн хувьцааны ногдол ашгийг хувьцаа худалдаж авсан этгээдүүд л авна. Засгийн газар зөвхөн зуучлалын үүрэг гүйцэтгэнэ. Таван толгойн хамтран ажиллагч гадаадынхан 30 хувийн хувьцааг худалдан авч, монголын талын эзэмших хувьцааны жин, захиран зарцуулах давуу эрхийг бууруулж мэднэ.

- Д. Батбаатар /"Иргэдийн шударга хөдөлгөөний тэргүүн" ТББ/: Эдийн засгийн тооцоогоор 30 жилээр 15 жилээр жилд 15 сая тонноор, 30 сая тонноор гэж тооцоод гаргасан байна. Та 15 сая тонноор гэж байна . 450 сая тонн нүүрс олборлох юм байна 30 жилийн хугацаанд. Үүний цэвэр ашиг нь болохоор 5 тэрбум 492 сая доллар. Тэгэхээр энийгээ бид нар өнөөдөр энэ хувьцаандаа хуваагаад үзэхээр үнэхээр нэг хүнд маань 15 тэрбум хувьцаандаа хуваахаар 1 хувьцаа маань 0,36 доллар буюу 536 хувьцаандаа хуваахаар 196 доллар болж байна 30 жилийн хугацаанд. Тэгэхээр 196 доллароо 30 жилийн хугацаандаа хувааж үзэхээр 1 хүнд сард ойролцоогоор 1,09 доллар ногдож байна. Тэгэхээр эдийн засгийн тооцоо үнэхээр ийм ашиггүй юм бол заавал ингэж хувьцаа хэлбэрээр ард түмэнд тараах нь зөв юм уу буруу юм уу.

(2011 оны 10 дугаар сар 20)

